

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр, Лхагва гараг

| | |
|---|-------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 1-18 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 19-70 |
| <hr/> | |
| 1.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 19-28 |
| 2.Аялал жуулчлалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ | 28-42 |
| 3.Элчин сайд нарыг томилох, эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023.04.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/ | 42-59 |
| 4.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ | 59-61 |
| 5.“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/ | 61-62 |
| 6.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 62-70 |

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сарын 03-ны өдөр /Лхагва гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 42 гишүүн хүрэлцэн ирж, 57.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 18 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Ц.Мөнх-Оргил;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, П.Анужин, Л.Оюун-Эрдэнэ, Ё.Баатарбилэг, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар, Д.Сарангэрэл, Ц.Сэргэлэн;

Тасалсан: Н.Ганибал, Х.Нямбаатар, Ч.Хүрэлбаатар;

Хоцорсон: С.Батболд- 51 минут, Ж.Бат-Эрдэнэ- 36 минут, Д.Ганбат- 21 минут, Х.Ганхуяг- 20 минут, Б.Дэлгэрсайхан- 37 минут, Д.Өнөрболор- 31 минут, Ц.Сандаг-Очир- 14 минут, Ж.Сүхбаатар- 1 цаг 10 минут, Г.Тэмүүлэн- 40 минут, О.Цогтгэрэл- 12 минут, Ц.Цэрэнпунцаг- 41 минут, Ж.Эрдэнэбат- 11 минут .

Нэг.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун, Ц.Амартөгс, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, мөн газрын ахлах шинжээч С.Сарангэрэл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газрын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Сувдмаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэх Ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор А.Алтанзул, Монгол Улсын Их сургуулийн зөвлөх профессор Р.Дарьхүү, мөн сургуулийн багш, дэд профессор Д.Оюунгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, С.Ганбаатар, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор А.Алтанзул нар хариулж, тайлбар хийв.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн талаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.2 дахь хэсэг нэмэх:

“9.2.Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, мөрдүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 28 |
| Татгалзсан: | 23 |
| Бүгд: | 51 |

54.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалтын “бодлого” гэсний дараа “, үндэсний хөтөлбөр” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 29 |
| Татгалзсан: | 21 |
| Бүгд: | 50 |

58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Засгийн газар нь” гэснийг “Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь” гэж, “Ёс зүйн дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 13.3-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 29 |
| Татгалзсан: | 21 |
| Бүгд: | 50 |

58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “төрийн албанаас” гэсний өмнө “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 30 |
| Татгалзсан: | 20 |
| Бүгд: | 50 |

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 20 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 30 |
| Татгалзсан: | 20 |
| Бүгд: | 50 |

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Г.Занданшатар: Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх” гэснийг “ажил хэрэгч саналыг үл хайхрах” гэж, 8.1.5 дахь заалтын “хясан боогдуулахгүй” гэснийг “хязгаарлахгүй” гэж, 8.2.3 дахь заалтын “мэдээллийг бусдад дамжуулах” гэснийг “мэдээллээр бусдыг” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “Дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 15.1.5-д заасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “тухайн албан хаагчийг дуудан ирүүлж,” гэснийг “тухайн албан хаагчаас биечлэн” гэж тус тус өөрчлөх, төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “10.1.” гэсний дараа “, 10.2” гэж нэмэх, төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 29 |
| Татгалзсан: | 21 |
| Бүгд: | 50 |

58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Г.Занданшатар: Төслийн 2 дугаар зүйлийн “37 дугаар зүйлийн 37.1.7,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 29 |
| Татгалзсан: | 22 |
| Бүгд: | 51 |

56.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд шилжүүлэв.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Уг асуудлыг 15 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Аялал жуулчлалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Аялал жуулчлалын бодлогын газрын дарга Т.Мөнх-Од, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

зүйн бодлогын газрын ахлах шинжээч Н.Жамьянхүү, “Монголын эрх зүйн судалгаа, хөгжлийн төв” Төрийн бус байгууллагын хуульч, судлаач Р.Лхагвабаяр, Хөвсгөл аймгийн Засаг даргын Аялал жуулчлал хариуцсан зөвлөх О.Мөнхнасан, “Лоок Монголиа” ХХК-ийн захирал Т.Баттулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Аялал жуулчлалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 21

Бүгд: 43

51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Хөтөч” гэсний өмнө “Аялал жуулчлалын мэргэжилтэй, эсхүл” гэж, мөн зүйлийн 10.2.2 дахь заалтын “үндэсний” гэсний өмнө “хууль тогтоомж,” гэж, 10.3 дахь хэсгийн “журмыг” гэсний өмнө, 10.4 дэх хэсгийн “чиг үүргийг” гэсний өмнө “болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох” гэж тус тус нэмж, мөн 10.4 дэх заалтын “журмын дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17

Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2 дахь хэсэг нэмэх:

“10.2.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэхэд энэ хуулийн 10.1-д заасан шаардлага хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Даатгал

15.1.Тур оператор, аяллын агент нь үйл ажиллагаандаа алдаа гаргасны улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

15.2.Өндөр уулын авиралт, спорт агнуур, олзворын ан, усны гүнд шумбах, авто спорт, нисдэг тэрэгний аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулна.

15.3.Энэ хуулийн 15.2-т зааснаас бусад эрсдэл бүхий аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд даатгуулж болно.

15.4.Энэ хуулийн 15.2-т заасан даатгалд хамруулах үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллага хариуцан зохион байгуулна.

15.5.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “хамгаалах, байгаль, түүх, соёлын өвийг” гэснийг “байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг” гэж, 19.5 дахь хэсгийн “мөрдөгдөх техникийн зохицуулалтад нийцсэн газар зохион байгуулалтын болон” гэснийг “аялал жуулчлалын үйл ажиллагаа, газар ашиглалтад холбогдох техникийн зохицуулалт, стандартыг мөрдөх бөгөөд түүнд нийцсэн” гэж, 19.7 дахь хэсгийн “газар зохион байгуулалтын нэгдсэн санд” гэснийг “газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд” гэж, 19.9 дэх заалтын “аймаг, нийслэлийн асуудал” гэснийг “аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал” гэж, мөн 19 дүгээр зүйлийг 16 дугаар зүйл болгон тус тус өөрчилж, 19.12 дахь хэсгийн “газар нутгийн” гэснийг, 19.6 дахь хэсгийн “газар зохион байгуулалтын болон” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

“19.8.Орон нутгийн аялал жуулчлалын бүс нь менежментийн төлөвлөгөөтэй байна. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалтын асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.9 дэх хэсэг нэмэх:

“19.9.Улсын аялал жуулчлалын бүсэд хамаарах аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 19.5-д заасан техникийн зохицуулалт, стандартыг мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.15 дахь хэсэг нэмэх:

“19.15.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа эрхлэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч хоорондын орон зайн төлөвлөлтөд холбогдох техникийн зохицуулалт, стандартыг заавал дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.13 дахь заалт нэмэх:

“4.1.13.“Аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөө” гэж аялал жуулчлалын бүсийн байгалийн нөөц, түүх, соёлын дурсгалыг хамгаалах, зохистой ашиглах, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн богино болон дунд хугацааны төлөвлөгөөг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 17

Бүгд: 40

57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 20 дугаар зүйлийг 17 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

17 дугаар зүйл.Отоглох цэг

17.1.Улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага отоглох цэг байгуулах байршлыг тогтооно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт отоглох цэгийг улсын төсвийн, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны, олон улсын төслийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн менежментийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа хэрэгжүүлэх бөгөөд менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

17.4.Энэ хуулийн 17.1-д заасан улсын аялал жуулчлалын бүс нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцаагүй тохиолдолд тухайн аялал жуулчлалын бүс дэх отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

17.5.Энэ хуулийн 17.4-т заасан отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх этгээдийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна.

17.6.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн үйлчилгээний хураамж авах, зарцуулахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

17.7.Отоглох цэг нь байнгын, эсхүл түр байж болох бөгөөд стандартын шаардлага хангасан байна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

17.8.Отоглох цэгт олон нийтийн аюулгүй байдлыг хангах харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 13
Бүгд: 40
67.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 12
Бүгд: 39
69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 27 дугаар зүйлийг 26 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

26.1.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн нэгдэл бүхий, ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

26.2.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

26.3.Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрэм, удирдлагын бүтэц, санхүүжилт, зохион байгуулалтын бусад асуудлыг бүх гишүүдийн хурлаар бие даан шийдвэрлэнэ.

26.4.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 14
Бүгд: 39

64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 32 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

32.1.Энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах хурлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хууль батлагдсан өдрөөс хойш 90 хоногийн дотор зохион байгуулна.

32.2.Энэ хууль батлагдсан өдрөөс өмнө байгуулагдан аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хамтран энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулна.

32.3.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хуралд оролцох байгууллагыг нээлттэй бүртгэх ба тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зохистой харьцааг хангаж хурлыг зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 17

Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС” гэж өөрчилж, 13 дугаар зүйлийг 18 дугаар зүйл болгон Гуравдугаар бүлэгт тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн Дөрөвдүгээр бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ БҮРЭН ЭРХ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15

Бүгд: 40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “6.5, 20.5,” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “, хэрэгжүүлэх асуудлаар санал гаргах” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.11.аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Аялал жуулчлалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар

Г.Занданшатар: Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөх:

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.14.Аялал жуулчлалын тухай хууль зөрчих

1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

1/33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгаль хамгаалал, соёл, аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагаар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахтай холбоотой харилцаанд энэ хуулийн 27.12-т

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

заасан журам үйлчлэхгүй бөгөөд хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж ашиглуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2/33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасан аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, бий болгох зорилгоор газар ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглах эрх олгоход Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-г заасныг үндэслэн сонгон шалгаруулалтыг хялбаршуулсан журмаар энэ хуульд заасны дагуу явуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн талаар

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Амьтны тухай хуульд доор дурдсан агуулгатай 29² дүгээр зүйл нэмсүгэй:

1/29² дүгээр зүйл.Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийн дуудлага худалдаа зохион байгуулах

29².1.Агнуурын амьтныг тусгай зориулалтаар агнах, барих эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу нээлттэй дуудлага худалдааны журмаар олгох бөгөөд дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж болно.

29².2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 26.3-д заасны дагуу гаргасан Засгийн газрын шийдвэр, агнуурын нарийвчилсан төлөвлөгөөг үндэслэн, тусгай зориулалтын ан амьтан агнах, барих тоо хэмжээг аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.

29².3.Дуудлага худалдааг тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталсан шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор нийтэд мэдээлж, 30 хоногийн дотор аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

29².4.Дуудлага худалдааг явуулах хугацааг товлосон шийдвэрийг дуудлага худалдаа явагдахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө гаргах ба дараах мэдээллийг тусгана:

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

29².4.1.дуудлага худалдаа явуулах он, сар, өдөр, цаг, хаяг;
29².4.2.тухайн аймагт ноогдох дуудлага худалдаанд оруулах тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо, төрөл зүйлийн жагсаалт;

29².4.3.дуудлага худалдааны босго үнэ, дэнчингийн хэмжээ, төлөх хугацаа;
29².4.4.хуульд заасан бусад.

29².5.Энэ хуулийн 29².4.3.-т заасан дуудлага худалдааны босго үнэ нь тухайн амьтны Засгийн газраас тогтоосон жишиг үнийн 20 хувь байна.

29².6.Дуудлага худалдааны дэнчин нь энэ хуулийн 29².5-д заасан босго үнийн 50 хувь байх бөгөөд дэнчинг дуудлага худалдаанд оролцохоос 24 цагийн өмнө урьдчилан төлж, бүртгүүлсэн байна.

29².7.Дуудлага худалдаанд ялсан оролцогчийн дэнчинг дуудлага худалдааны үнийн дүнд оролцуулан тооцох ба ялаагүй оролцогчийн дэнчинг 14 хоногийн дотор буцаан олгоно.

29².8.Дуудлага худалдаанд хоёр, түүнээс дээш этгээд оролцох хүсэлтээ ирүүлж, үнийн санал өгсөн тохиолдолд дуудлага худалдааг хүчинтэйд тооцно.

29².9.Дэнчин төлж бүртгүүлсэн этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дуудлага худалдаанд оролцоно.

29².10.Дуудлага худалдаанд ялсан этгээд нь дуудлага худалдааны үнийг дуудлага худалдаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор төлнө.

29².11.Дуудлага худалдааны ялагч нь энэ хуулийн 29².10-т заасан хугацаанд дуудлага худалдааны үнийг төлөөгүй тохиолдолд дэнчингээ алдах ба дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээдэд санал тавина.

29².12.Дуудлага худалдаанд хоёр, түүнээс дээш оролцогч оролцоогүй, эсхүл үнэ хаялцаагүй, эсхүл энэ хуулийн 29².11-т зааснаар дараагийн өндөр үнийн санал гаргасан оролцогчид тавьсан саналыг хүлээн аваагүй тохиолдолд дуудлага худалдааг хүчингүй болгож, 14 хоногийн дотор хоёр дахь дуудлага худалдааг явуулна.

29².13.Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч бол тусгай зөвшөөрлийг өөрийн менежмент хариуцдаг агнуурын бүс нутаг дээр бүртгүүлж, баталгаажуулна.

29².14.Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчаас өөр этгээд бол тухайн аймгийн аль нэг агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчтай ан агнуулах гэрээ байгуулна.

29².15.Аймаг, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдааны төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, хураамжийг төлсөн баримт, энэ хуулийн 29².14-т заасан гэрээг үндэслэн ан агнах тусгай зөвшөөрөл олгоно.

29².16. Энэ хуулийн 29².15-д заасан тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй.

29².17.Дуудлага худалдааны үнийн дүнгийн орлогыг Төсвийн тухай хуулийн 23.7.4, 23.9.4-т заасны дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

29².18. Дуудлага худалдаанаас орсон орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэний дараа үнийн дүнгийн 20 хувийг агнуурын бүс нутгийн амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээнд зориулан менежмент хариуцагчид олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Г.Ганболд, Ж.Батжаргал, Х.Ганхуяг нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас Аялал жуулчлалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Дөрөв.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 23 |
| Татгалзсан: | 18 |
| Бүгд: | 41 |

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Аялал жуулчлалын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Элчин сайд нарыг томилох, эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023.04.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дэд захирал Д.Амарсайхан, Элчин сайдад нэр дэвшигч С.Золжаргал, Б.Баярсайхан, Б.Энхбат, Э.Сарантогос нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ нар байлцав.

Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг томилох, эгүүлэн татах асуудлаар зөвшилцөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нар танилцуулав.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Танилцуулга болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Д.Өнөрболор, Ц.Даваасүрэн, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Н.Энхболд, Н.Учрал, Г.Дамдинням, Э.Бат-Амгалан нарын тавьсан асуултад Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, нэр дэвшигч Б.Энхбат нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.2-т заасны дагуу Байнгын хорооны саналаар Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар нууц санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэгийг, Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргалыг, Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогосыг, Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболдыг эгүүлэн татах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 12
Бүгд: 44
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.2-т заасны дагуу Байнгын хорооны саналаар Монгол Улсаас гадаад улсад суух Элчин сайд нарыг томилох асуудлаар нууц санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сэсээрийн Золжаргалыг томилох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 10
Бүгд: 45
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Баярсайханыг томилох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 13
Бүгд: 46
71.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

3.Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбатыг томилох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Эрдэнэцогтын Сарантогосыг томилох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 37
Татгалзсан: 9
Бүгд: 46
80.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар явагдсан санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 18 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 46¹.1 дэх хэсгийн “Шаардлагатай” гэсний өмнө “Засгийн газар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 6 дугаар зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг,” гэснийг “3 дугаар зүйлийг,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 21
Бүгд: 46
54.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бат.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 22
Бүгд: 45
51.1 хувийн саналаар дэмжигдлээ.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зургаа.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, Д.Тогтохсүрэн, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул хариулж, тайлбар хийв.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Ц.Даваасүрэн, Б.Пүрэвдорж /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, 1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.3.6 дахь заалтын “сурталчлах” гэснийг “сурталчлахтай холбоотойгоор гадаад улсаас бараа, үйлчилгээ авах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 21 |
| Татгалзсан: | 18 |
| Бүгд: | 39 |

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажлын цаг дууссан тул санал хураалтыг маргааш үргэлжлүүлэн хэлэлцэхээр тогтов.

Бусад. Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан Парламентын сэтгүүлч, зурагчин, зураглаачид, “Парламентын боловсрол” хөтөлбөрт хамрагдаж буй ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн 126 ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн урилгаар ерөнхий боловсролын “Глобал инновэ” сургуулийн 12 а, б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Б.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

эрхэлдэг хоршоодын дарга нар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 22 минут үргэлжилж, 73 гишүүнээс 59 гишүүн хүрэлцэн ирж, 80.8 хувийн ирцтэйгээр 18 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их Хуралдай” танхим
15 цаг 18 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Гишүүдийн ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сарын 03-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна.

1 дүгээрт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрөөтэй 7 саналтай.

2 дугаарт, Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг. Боловсролын хууль чинь биш Боловсролын хууль өнөөдөр ингээд хэлэлцүүлэг явж байгаа учраас маргааш өглөө хэлэлцэнэ. Үүнийг амжихгүй болж байна. Санал хураалт дуусаагүй, Байнгын хорооны байгаа учраас.

2 дугаарт, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Зарчмын зөрөөтэй 27 саналтай.

3 дугаарт, Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлаар зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

4 дүгээрт, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

6 дугаарт, “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

6 дугаарт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлнэ. Анхны хэлэлцүүлэг. 39 зарчмын зөрөөтэй саналтай.

Ингээд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Балжиннямын Баярсайхан танилцуулна.

Б.Баярсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ, Баярсайхан нарын 4 гишүүнээс 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд шилжүүлсэн.

Ёс зүй сахилга хариуцлагын байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Баделхан ажлын хэсгээс гаргасан зарчмын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

зөрөөтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авлаа.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Занданшатар төрийн албан хаагчийн сахих ёс зүйн хэм хэмжээг тогтоох зайлиггүй шаардлага тулгарч байгаа өнөөгийн цаг үед хууль батлагдсанаар бүх шатанд хүнд суртал, зөрчил, шударга бус явдлыг таслан зогсоох, нийт төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхэд онцгой анхаарч, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар санал хэллээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Байнгын хорооны хуралдаанаар явуулахад Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан зарчмын зөрөөтэй б санал, найруулгын 1 саналын томъёоллоор санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналыг

хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны та санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Адъяаа гишүүнээр, Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Төрийн албаны зөвлөлийн дарга Балдангийн Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Бадамцоогийн Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Цэнддаваагийн Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Чандагийн Эрдэнэбат, ЗГХЭГ-ын Хүний нөөцийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Туулын Сувдмаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын албаны дарга Доржсүрэнгийн Дуламсүрэн, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын ахлах шинжээч Сүндэвийн Сарангэрэл, Удирдлагын академийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор Алтангэрэлийн Алтанзул, МУИС-ийн зөвлөх профессор Ренчингийн Дарьхүү, МУИС-ийн багш, дэд профессор Дашдоржийн Оюунгэрэл.

Ширнэнбаньдын Адъяаа гишүүн асуулт асууна.

Ш.Адъяаа: Өнөөдөр Монгол Улсын Их Хурал төрийн албаны ёс зүйн тухай хуулийг хэлэлцэж батлах гэж байна. Төрийн албаны ёс зүйн асуудал төрд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагын асуудал, өнөөдөр энэ хуулиар зохицуулагдах ийм шаардлага үүссэн. Сүүлийн жилүүдэд төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагын улмаас төрд итгэх итгэл, хуульд итгэх итгэл алдарсан ийм цаг үе, ийм хугацаатай бид олон жил бас сайн, муу талыг нь харж ажиллаж ирсэн. Энэ

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

сахилга хариуцлагын асуудал, ёс зүйн асуудлыг бид энэ хуулийн хэмжээнд төрийн бодлогын хэмжээнд засаж залруулах, хуулиар дамжуулж энэ бодлогыг явуулах асуудал өнөөдөр нийгмийн захиалга болсон. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Ер нь энд олон хүний бас их хүч хөдөлмөр, олон зүйл энд яригдлаа. Сахилга, хариуцлагын асуудлыг ингэж хуульчлахын зэрэгцээ төрийн албанд ажиллаж байгаа хүмүүсийн нийгмийн бодлогын асуудал, тэр хүмүүсийн ажиллах нөхцөл, орон байр, хөдөлмөрлөх нөхцөлийн асуудлыг бас Монголын төр цаашид хууль тогтоомжийн хүрээнд бас авч үзэх нь шударга ёсонд нийцэх байх гэж бодож байгаа.

Энэ хуулийн төсөл батлагдаж, хэрэгжсэнээрээ Монголын төрд ажиллах, төрийн албанд ажиллах хүмүүсийн ёс зүй, сахилга хариуцлагын хэм хэмжээнд шинэ өөрчлөлт авч ирэх байх аа гэж бодож байгаа. Энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд орон нутагт ажилладаг, нэн ялангуяа орон нутгийн төр захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагын асуудал дээр тухайн орон нутгийн байгууллагыг удирдаж байгаа яам, тамгыг удирдаж байгаа хүмүүс энд шинэ эргэлт хийх ёстой, эргэлт хийх ёстой. Өнөөдөр бид ийм байдлаар сахилга, хариуцлага ёс зүйг хэрэгжүүлэхгүйгээр, хуулийг хэрэгжүүлэхгүйгээр ингээд явсаар байгаад Монголын нийгэм ямар байдалд орсон бэ гэдэг дээр бид дүгнэлт хийх ёстой. Энэ асуудал өнөөдөр төрийн алба ч биш ер нь Монголын иргэн бүр, нэн ялангуяа залуу үеийн зүрх сэтгэл, тэдний бодлыг өөрчлөхөд төрийн алба, Монголын төр эндээс эхлэх ёстой гэсэн ийм л байр суурьтай байгаа.

Тийм учраас энд энэ хуулийг хэрэгжүүлэхэд манай төрийн байгууллагууд, түүнчлэн төрийн албан хаагчид манлайлал үзүүлж ажиллах байх гэж ингэж бодож байна. Энэ хуулийн

төслийг ингэж дэмжиж байгаа. Надад асуулт байхгүй.

Г.Занданшатар: Баярлалаа Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Би Хууль зүйн байнгын хороонд байдаггүй болохоор бас тодруулж асууж байгаа юм шүү. Энэ төрийн албан хаагчид, ялангуяа төрийн захиргаа, үйлчилгээний албан хаагчдын цалин амьжиргаанд нь хаана ч хүрэхгүй байгаа. Тэгээд бид хариуцлага ярилгүй л яах вэ. Гэхдээ төрөөс яг шалтгаалж байгаа зүйлүүдээ юу хийж байгаа вэ гэдэг дээр бид бас бодох цаг болсон.

Тэгээд миний тодруулж асуухыг хүсэж байгаа зүйл нь юу вэ гэвэл тодруулж та нарын анхааралд оруулахыг хүсэж байгаа зүйл бол сая энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл харин сайн болсон юм шүү. Түүний хуудас 575 дээр нэг үг байгаа. 2021 онд төрийн албаны тухай хуульд 2021 онд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа 39 дүгээр зүйлийн жинхэнэ гэдэг үгийг хасчихсан. Уг нь төрийн жинхэнэ албан хаагчид гээд та нар бүр яг томьёоллоор нь уншвал цаг идэх байх. Шууд ойлгож байгаа байх. Төрийн жинхэнэ албан хаагчдын эрх ашгийг боомилсон байгаа. Тэр нь бол улс төрийн албан хаагчид, тэр захиргааныхан байдаг байх, тагнуул, цагдаагийнхан байдаг байх. Гэтэл өнөөдөр энэ жинхэнэ гэдэг үгийг хассанаараа бүх төрийн албан хаагч нарт эрх ашгаа хамгаалж, өөрсдийнхөө үзэл бодлоо илэрхийлэх, санаа бодлоо ярих, цалин хөлснийхөө талаар хэлэлцээрт орох эрхийг нь 100 хувь хасчихсан байгаа. Энэ өөрчлөлтөөс болж төрийн үйлчилгээнийхэн бүгдээрээ, төрийн захиргааныхан, төрийн албан хаагчид бүгдээрээ жагсаал цуглаанд оролцох, цаашилбал эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө, хамтын хэлэлцээрт орох эрхийг нь шууд хасчхаж байгаа юм. Энэ талаар Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах ёстой шүү гэж Хүний эрхийн Үндэсний Комисст заасан байна.

Комиссын илтгэлд. Энэ талаар та нар санал оруулсан уу. Төрийн албаны тухай хуулийн 58.1.1-ийг ярьж байгаа шүү би, та нар яг харах юм бол, энэ зөрчиж байна аа гэж би ойлгож байна. Ингээд үүгээр энэ талаар та нар онцгой анхаарах ёстой.

2 дугаар зүйл, энэ хууль дээр холбогдуулаад асуухад энэ халах гэдэг хариуцлага ногдуулалт ер нь манай эрх зүйн орчинд байдаг юм уу? Халах гэдэг үг орчихсон байгаа байхгүй юу. Хөдөлмөрийн харилцааны л үг байх ёстой шүү дээ. Халах гэдэг хариуцлага ногдуулалт бараг шийтгэлийн хойшид үр дагаврын талаар ямар нэгэн хязгаарлалт үүсдэггүй ээ. Энэ үр дагаврын эрх зүйн үндсийг нь нэг тайлбарлаж өгөөч. Төрийн албан хаагчдын ёс зүйгээ зөрчсөнөөс сайн дураараа албан тушаалаасаа чөлөөлөгдөнө өө гэж заасан байгаа. Хариуцлага хүлээлгэхийг, бүр хариуцлага хүлээлгэхийг өөрөө хүсээд байхад нь бид нар 16.3-д зааснаар 15.1.5-д бас заасан байгаа. Төрийн албанаас халах хариуцлагыг шийтгэлийг ноогдуулж болохоор байна аа гэж. Энэ дээр эрх зүйн үндсийг нь тайлбарлаж өгөөч.

2 дугаарт, төрийн албанаас чөлөөлөх болон халах хариуцлагын үр дагавар ямар байх вэ, үр дагаврын эрх зүйн үндэслэлийг нь тайлбарлаж өгнө үү гэдэг энэ миний асуулт шүү. Төслөөр бол 4.1-д энэ хуулийн үйлчлэлд улс төрийн, төрийн захиргааны, төрийн тусгай, төрийн үйлчилгээний төрийн албан хаагч бүгд хамаарахаар болчихсон байна. Яг нарийн яривал. Тэгэхээр миний асуулт бол Үндсэн хуулийн 46.2-т төрийн жинхэнэ албан хаагчийн тухай тодорхой заалт байгаа. Хуулийн төслийн халах гэсэн ёс зүйн хариуцлага шийтгэл төрийн бүх албан тушаалтанд хамаарахын үр дагавар ямархуу байдлаар илрэх бол гэдэг дээр та нар судалгаа хийсэн байх. Бидэнд тодруулж өгөөч ээ. Уг нь Хөдөлмөрийн хуульд хөдөлмөрийн эрхлэлтийн

харилцааг цуцлах гэдэг үг байгаад байгаа байхгүй юу.

Г.Занданшатар: Энэ төрийн албаны ёс зүйн хууль яг төрийн албаны хууль биш л дээ. Тэгэхдээ хуультай шууд холбоогүй ч гэсэн хариулчихъя. Баатарзориг дарга хариулах уу? Багш хариулах уу, Алтанзул багш хариулах юм уу? 84 Маргаан хянан шийдвэрлэх, биш ээ биш. 84.

Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Бат-Эрдэнэ байна. Төрийн албаны тухай хуульд 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан байдаг. Энэ өөрчлөлт нь ямар шалтгаанаар орсон бэ гэхээр Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж энэ төрийн албаны тухай хуульд өөрчлөлт орсон байдаг. Сая эрхэм гишүүний хэлсэнтэй санал нэг байгаа. Уг нь энэ төрийн жинхэнэ албан хаагч гэдэгт Төрийн албаны тухай хуулиар төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчид хамаардаг. Тийм учраас энэ Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл гэдэг энэ зүйлийнх нь өөрийнх нь концепц нь төрийн жинхэнэ албан хаагчдад хамаарахаар ийм үзэл санаагаар анх 2017 онд батлагдаад, 2019 оны 01 сарын 01-нээс дагаж мөрдөж эхэлсэн байдаг. Тийм учраас энэ Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж орсон энэ өөрчлөлттэй холбоотойгоор яг саяын таны хөндсөн энэ асуудлыг залруулах, өөрчлөх энэ асуудлыг бас холбогдох судалгаагаа хийж байна. Эрх бүхий байгууллагуудад бас саналаа хүргүүлэхээр бид бүхэн ажиллаж байгаа юм.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүнд. Алтанзул доктор 80.

А.Алтанзул: Ганбаатар гишүүний асуултад хариулъя, 2 дахь асуултад нь хариулъя. Ер нь Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль болон Төрийн албаны хуулийн гол зарчим бол Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан төрийн бүх албан тушаалын ангилалд хамаарах албан тушаалтнууд орно. Тэр нь төрийн, улс төрийн, захиргаа, жинхэнэ захиргаа тусгай, үйлчилгээний гээд. Тэгэхээр аль нэгэн зохицуулалтыг бид нар тусгайлан авч үзнэ ээ гэдэг нь нөгөө тэгш байдлыг хангах зарчимтай зөрчилдөж байгаа.

Төрийн албанаас халах гэдгийг бид нар тодорхой тохиолдолд бид нар зааж өгсөн. Өөрөөр хэлбэл энэ ёс суртахууны харилцаа буюу төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг хуульчилж байгаа учраас заавал хуульд үүрэг, хориглох зүйлийг тодорхойлж өгдөг. Үүрэг, хориглох зүйл байгаа тохиолдолд хариуцлага гарцаагүй байна гэдэг зарчим үйлчилнэ. Тийм учраас бид нар энэ ёс суртахууны хүрээнд энэ хуулиараа ёс суртахууны ёс зүйн хариуцлага хүлээлгэх процесст бид нар хөнгөнөөс хүндрүүлэх шинжээр нь буюу анхан болон давтан үйлдсэнийг нь харгалзан ёс зүйн хариуцлага хүлээлгэж байгаа. Яг төрийн албанаас халах гэдэг зохицуулалт нь бид нар юу гэж одоо энэ найруулгаар юу гэж засаж орж ирсэн бэ гэхээр Төрийн албаны хуульд зааснаар бид нар төрийн албанаас халах гэдэг зохицуулалт орж ирнэ. Тэгэхээр төрийн албанаас халах зохицуулалт бол хариуцлага хүлээлгэж байгаа зохицуулалт. Тэр нь төрийн үйлчилгээний байна уу, захиргаа байна уу, улс төрийн байна уу бүгд тэгш байдлаар хариуцлага хүлээх ёстой.

Төрийн албанаас чөлөөлөх гэдэг маань өөрөө тусгай хууль зүйн үндэслэлтэй, өөрөөр хэлбэл тэтгэвэрт гарч байгаа тохиолдол, өвчин эрүүл мэндийн шалтгаанаар бол чөлөөлөгдөнө. Энэ бол тэр хариуцлага буюу сахилга ёс зүй зөрчсөн үйлдэлтэй энэ хамаарахгүй. Халах гэдэг нөгөө сахилга, хариуцлагатай

холбоотой зохицуулалт. Харин энэ хуулийнхаа томъёолол дээр бид нар ёс зүйн хариуцлага эхний удаа хөнгөн шинжээр бид нар тийм ээ, өөрөөр хэлбэл анх удаа үйлдэж байгаа тохиолдолд уучлал гуйлгуулна, сануулна гэсэн зохицуулалт байна. Харин энэ үйлдлээ давтан гаргаад байх юм бол Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулахаар хуулиа уялдуулсан байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Шууд холбогдохгүй байгаа учраас болох байх. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ Төрийн албаны ёс зүйн тухай хуулийг бидний нэр бүхий хэдэн гишүүд Улсын Их Хуралд өргөн барьсан. Үүнтэй зэрэгцүүлээд би хэлэх юм бол Улсын Их Хурлын дарга Занданшатар Засгийн газрын Хэрэг эрхлэхийн дарга байхаасаа энэ хууль дээр эрдэмтэн, судлаачидтай хамтарч ингэж ажиллаж байсан. Манай энэ хуулийн төсөл дээр Монгол Улсын урдаа барьдаг нэртэй хуульчид орж ажиллаж өгсөн. Энд бид их талархалтай байгаа. Тухайлах юм академич Нарангэрэл багшийг хэлж болно, Алтанзул доктор байна, Дарьхүү доктор байна. Манай Төрийн албаны зөвлөл бүрэлдэхүүнээрээ ажиллалаа. Авлигатай тэмцэх газар, холбогдох бүх байгууллагууд, эрдэмтэд, судлаачдад талархал илэрхийлье. Үүний зэрэгцээгээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо манай Баттөмөр даргын ахалсан Байнгын хороо ихээхэн хичээл, чармайлттай ажиллаж энэ хуулийг ингээд босгоод ирлээ гэж. Ер нь үнэхээр төрийн албанд ёс зүйн асуудал яригдах ёстой юу гэвэл яригдах ёстой, өөр арга байхгүй. Өнөөгийн нийгмийн харилцаа энэ шаардлага чинь бид нараас шаардаж байна шүү дээ. Бид 2010 онд одоогоос 13 жилийн өмнө Улсын Их Хурлын ёс зүйн дүрмийг анх Их Хурлаар оруулж, батлуулахад үнэхээр амаргүй бас ийм хүнд нөхцөл дундуур батлуулж байсан. Ер нь зүгээр Монголд биш энэ дэлхийн

бусад улс орнуудад энэ парламентад гишүүдийн ёс зүйн дүрмийг батлуулах амаргүй юм байна лээ. Ингээд үргэлжлүүлээд бид нар энэ 2000-2024 оны Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд энэ Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хороог өргөтгөж байгуулаад, ингээд манай Байнгын хорооноос бид бас мөн хуулийн төсөл санаачлаад энэ Улсын Их Хурлын гишүүдийнхээ ёс зүйн дүрмийг шинэчилсэн найруулгаар хуульчилж баталсан. Энд манай энэ 20 оноос сонгогдож ажиллаж байгаа Их Хурлын гишүүддээ би тусгайлан баяр талархал дэвшүүлэе гэж бодож байгаа юм. Энэ бол дээрээсээ бид нар үлгэр жишээ үзүүлэх ёстой. Ёс зүйн энэ хариуцлага сахилгыг бид дээд талаасаа үлгэрлэж сахих ёстой, дээрээсээ шатны гишгүүрийг шүүрдэнэ ээ гэдэг энэ зарчим дээр манай Их Хурал ингэж ажиллалаа. Зарим нэг улсууд одоо ч гэсэн энэ хуулийн хэлэлцүүлэг явагдаж байхад шивэр авир гээд араар эсэргүүцэж байгаа улсууд байгаа.

Бид энэ төрийн албан хаагчдаас ёс зүй, сахилга хариуцлага нэхэхийн зэрэгцээгээр мэдээж төрийн албан хаагчдын цалин, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг нь бид давхар л авч үзэх ёстой. Энэ асуудлыг бас Их Хурал, Засгийн газар дээр ялангуяа энэ салбар болгоны цалин, нийгмийн хамгааллын ялгамжтай байдлыг хэт ялгамжтай байдлыг арилгах чиглэлээр ингээд тодорхой бодлогууд гараад энэ дэс дараалалтай арга хэмжээнүүд авагдана, яригдана. Өнөөдөр энэ ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх асуудлаас ухрах ийм нөхцөл байдал байж болохгүй ээ, нөхөд минь. Энэ дээр та бүхэн маань санал нэгдэх байх. Энэ чинь дээрээсээ эхэлсэн муугийн үлгэр жишээ гэдэг чинь доошоо тунараад энэ төрийн дунд, доод шатанд ажил алба, шийдвэр гаргах түвшинд байж байгаа улсууд чинь энэ авлига, хээл хахууль, хулгай, худалдаа холбогдоод зүгээр гэрнээс нь сейфнээс нь хэчнээн тэрбум төгрөг алт, юу юу ч гэнэ

вэ гарч байдаг ийм юм боллоо шүү дээ. Ингээд байж байхад чинь бид нар зүгээр дүлий дүмбэ сууж байж болохгүй. Энэ чинь дээд талаасаа Их Хурал бол нэлээн овоо цэгц журамдаа орж байна гэж би бас 5 удаа сууж ажиллаж байгаа хүний хувьд би ингэж дүгнэж байгаа. Бид нар ингээд бүх түвшиндээ ингээд ажиллах ёстой. Бид нар өөрсдийнхөө ... /минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэлчихлээ.

Зочид танилцуулъя.

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан парламентын сэтгүүлчид, зурагчин, зураглаачид, хэвлэл мэдээллийн ажилтнууд маань Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Эрхэм хүндэт сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд та бүхэндээ Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийн мэндийг өргөн дэвшүүлэе. Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн шийдвэрээр жил бүрийн 05 дугаар сарын 03-ны өдрийг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр болгон тэмдэглэж, зарлан тунхаглаж ирсэн. Манай улс 30 дахь жилдээ Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тэмдэглэж байна. Хэвлэн нийтлэх эрх чөлөө бол ардчиллын үнэт зүйл юм. Монгол Улс Үндсэн хуулиараа үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, ардчиллын мөн чанарыг улам тодотгож өгсөн нь бидний энэ 20 дугаар зууны хамгийн том ололтуудын нэг юм. Өнгөрсөн жил энэ парламентын ажлыг ил тод, нээлттэй болгох, парламентын шинэчлэлийг хэрэгжүүлэх, ард түмний засаглах эрхийг хангах, ил тод, нээлттэй парламент хууль тогтоох ажиллагаа байх явдлыг манай сэтгүүлчид байнга дэмжиж, парламентын хяналт шалгалт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, нээлттэй сонсгол зохион байгуулах, төрд итгэх иргэдийн итгэлийг сэргээх талаар хамтран ажиллаж ирсэн явдалд үе үеийн

парламентын сэтгүүлчид та бүхэнд халуун талархал илэрхийлье. Баяр хүргэе.

Ийм ч учраас парламентын сэтгүүлчид та бүхэн маань хууль тогтоогчдоос дутахааргүй мэдээлэлтэй, бас мэдлэгтэй, сайн хууль батлан гаргахын төлөө ажилладаг, бас шүүмжилдэг болох болохгүйг нь, жинхэнэ 4 дэх засаглалын үүргээ гүйцэтгэж ирсэн гэдгийг тэмдэглэн хэлэхдээ таатай байна. Хууль сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих энэ эргэх холбоог үүсгэхэд хэвлэл мэдээллийн салбарын үүрэг оролцоогүйгээр парламент ажиллах ямар ч бололцоогүй. Тиймээс Монгол Улсын парламентын сэтгэл зүйг, парламентын сэтгүүл зүйг хөгжүүлэхэд та бүхний оруулсан хувь нэмрийг үнэлж баршгүй юм. Сэтгүүлчийн ажил арилжаа наймаанаас илүү үнэтэй, улс төрөөс илүү хүчтэй, ард түмнийг уриалан дуудах агуу урлаг юм аа гэж Балдорж агсан нэгэнтээ хэлсэн байдаг. Тэгээд энэ үг бол сэтгүүлчийн ажлыг яруу тодоор илэрхийлсэн сайн зүйрлэл юм.

Тэгээд өнөөдөр бид мэдээллийн шинэ эрин зуунтай хөл нийлүүлэн алхаж байна. Монголын сэтгүүлчдийн бэлтгэсэн мэдээллийн чанар, хурд олон улсын мэдээллийн агентлагуудтай харьцуулан харагддаг, үнэлэгддэг болсон. Бодит нөхцөл байдлыг халуун цэгээс нь хүргэх, тэнцвэртэй мэдээлэх, эх сурвалжийг нотлох зэрэг мэдээ, мэдээлэл бэлтгэх ур чадвар дэлхийн жишигт хүрсэн. Тиймээс өнөө цагийн цахим мэдээллийн хурд сэтгүүл зүйн салбарыг улам хариуцлагатай, ёс зүйтэй, үнэн бодитой, тэнцвэртэй байхыг шаардаж байгаа.

Хэвлэлийн эрх чөлөөний энэ өдөр Монголын сэтгүүл зүйн орчин тэр дундаа хууль эрх зүйн хүрээнд сэтгүүлчдийн эрх хэрхэн зөрчигдөж байгаа тухай, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хэрхэн боогдуулсан, хараат бус сэтгүүл

зүйг хөгжүүлэхэд тохиолдож буй саад бэрхшээлийн талаар бас бид ярилцах нь зүйтэй. Ийм учраас 4 дэх засаглалынхаа редакцын хараат бус байдал болон мэргэжлийн ёс зүйн асуудлыг хэлэлцэхээс гадна иргэд олон нийтэд хэвлэлийн эрх чөлөөг хэрхэн хааж, боогдуулсан талаарх үнэн бодит мэдээллийг хүргэж, төр засагт хэвлэлийн эрх чөлөөг сануулах үүрэгт энэ 05 дугаар сарын 03-ны өдрийг Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тэмдэглэхийн утга учир юм.

Монгол Улсын парламент нэг дэвшилттэй шийдвэр гаргасан нь Эрүүгийн хуулиас гүтгэхтэй холбоотой заалтыг хассан. Цаашид хэвлэлийн эрх чөлөөг хангахад хууль, эрх зүйн орчныг сайжруулах, сэтгүүлчдийн хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, цахим сэтгүүл зүйг дэмжих зэрэг олон асуудлууд бий. Эрхэм сэтгүүлчид та бүхний үг тань үнэн, үзэг тань хурц байх болтугай. Та бүхэнд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар санал хураалт явуулна. 7 санал байгаа. Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

1.Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.2 дахь хэсэг нэмэх:

“9.2.Улсын Их Хурал төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг баталж, мөрдүүлнэ.” Санал гаргасан Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо. Санал хураалт явуулна. Гишүүд анхааръя. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалт.

54.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.6.1 дэх заалтын “бодлого” гэсний дараа “, үндэсний хөтөлбөр” гэж нэмэх. Санал гаргасан Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо. Санал хураалт.

Дашдондогийн Ганбат гишүүн суудал аа. Анхаар, анхаар, анхаараарай. Энхтүвшин гишүүн. Санал.

58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “Засгийн газар нь” гэснийг “Засгийн газрын дэргэдэх Ёс зүйн хороо нь” гэж, “Ёс зүйн дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 13.3-т заасан” гэж өөрчлөх. Санал гаргасан Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, санал хураалт.

58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалтын “төрийн албанаас” гэсний өмнө “Төрийн албаны тухай хуульд заасны дагуу” гэж нэмэх. Санал гаргасан Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Төслийн 20 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, санал хураалт.

30 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

1. Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “ажил хэргийн санаа бодлыг үл хүндэтгэх” гэснийг “ажил хэрэгч саналыг үл хайхрах” гэж, 8.1.5 дахь заалтын “хясан боогдуулахгүй” гэснийг “хязгаарлахгүй” гэж, 8.2.3 дахь

заалтын “мэдээллийг бусдад дамжуулах” гэснийг “мэдээллээр бусдыг” гэж, төслийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “Дэд хорооны” гэснийг “энэ хуулийн 15.1.5-д заасан” гэж, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “тухайн албан хаагчийг дуудан ирүүлж,” гэснийг “тухайн албан хаагчаас биечлэн” гэж тус тус өөрчлөх, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “10.1.” гэсний дараа “, 10.2” гэж нэмэх, төслийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан” гэснийг хасах. Санал гаргасан Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, санал хураалт.

58 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд.

Ард нь 1.

Төрийн албаны ёс зүйн тухай хуулиар санал хураалт явуулж дууссан.

Одоо төрийн албаны хууль дагалдаж баталсан хуулийн талаар санал хураалт явуулъя. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

1. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

1. төслийн 2 дугаар зүйлийн “37 дугаар зүйлийн 37.1.7,” гэснийг хасах. Санал гаргасан Ёс зүй, сахилга

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

хариуцлагын байнгын хороо, санал хураалт.

56.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд шилжүүлж байна.

Үндсэндээ ингээд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль үндсэндээ батлагдаж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл өргөн баригдсан бас хэлэлцэгдэх гэж байна. Тэгэхээр энэ үед Улсын Их Хурлын гишүүд л ерөөсөө огт болохгүй байгаа юм шиг, дээрээ ерөөсөө суудлаа олохгүй байна. Энэ авлига, хээл хахууль, гэмт хэрэгт холбогдсон асуудлууд төрийн албаны нэр хүндийг унагааж байна гэсэн ийм шүүмжлэх байгаа. Тэгэхээр ер нь хууль бодитой хэрэгжих үндэс нь хуулийн амин сүнс нь бол ёс зүй. Ийм учраас Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг бусад орнуудын Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дүрэм, олон улсын нийтлэг стандартуудыг нарийвчлан судалж, төрийн байгууллага, олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нэгтгэн энэ цаг үеийн шаардлагад нийцүүлж боловсруулсныг Улсын Их Хурал өнөөдөр эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Энэ гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

Өнөөдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нартай уулзсан. Энэ хуулийг сайшаан дэмжиж байна. Түүрүүн Бат-Эрдэнэ гишүүн хэлсэн, шатыг дээрээс нь эхэлж шүүрддэг. Энэ “шүүр” ажиллагаа доороо буужигнуулах биш дээрээс нь эхэлж болох болохгүйг

шүүрдэж засах хэрэгтэй. Энэ ёс зүйн тухай хууль яг энэ рүү чиглэгдэж байгаа.

Улсын Их Хурлын гишүүдээс авхуулаад төрийн өндөр албан тушаалтнууд энэ хуулиар зээл авахад нөлөөлөх, хөнгөлөлттэй зээл тусламжийн хөтөлбөрт хамрагдахад нөлөөлөх, өөрсдийн хамаатан, ах дүү, төрөл төрөгсдийг ажилд томилоход нөлөөлөх, ер нь аливаа хэлбэрээр бусдад давуу байдал олгохоор хувийн ашиг сонирхлын үүднээс нөлөөлөх үйлдэл гаргах юм бол үүнийг ёс зүйн зөрчил гэж үзэж, Улсын Их Хурлын гишүүнээс эргүүлэн татах хүртэл энэ хариуцлагын механизмыг ёс зүйн дүрмээр бий болгосон. Харин үүнийг ажиллах механизм нь энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль байгаа юм. Энэ төрийн 4232 нэгж дээр Ёс зүйн зөвлөл ажиллана. Энэ ёс зүйн зөвлөл бол 3 талт ажил олгогч, татвар төлөгчид, хэрэглэгчид, энгийн иргэдийн төлөөлөл энэ Ёс зүйн зөвлөлд орж, хяналт тавьж байх учиртай. Ингэснээрээ бүх шатанд дарга нар нь, сайд нар нь, гишүүд нь хууль бус шаардлага тавьж энэ тендерийг ингээд шалгаруулаач, энэ хүнийг ингэж ажилд томилооч, аль эсвэл хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулаач гэсэн аливаа нөлөөллийг энэ таслан зогсоох Ёс зүйн зөвлөл бүх шатанд ажиллах ийм шахалт шаардлага үзүүлж байгаа бол дарамт шахалт үзүүлсэн гээд тэр Ёс зүйн зөвлөлөөр хэлэлцээд бүх асуудлууд цэгцэрнэ. Ингээд төр дээрээсээ авхуулаад доороо хүртэл ёс зүйтэй байж байж, энэ авлига, хээл хахууль, хулгай зэлгий цэгцэрнэ. Ийм учраас энэ Ёс зүйн дэд хороог, Ёс зүйн зөвлөлийг бүх шатанд бүх албан байгууллага дээр байгуулагдана. Энд нь хяналт тавих Мэргэжлийн ёс зүйн хороо Төрийн албаны зөвлөлийн дэргэд ажиллана.

Одоо манай Нарангэрэл академич шиг тэр хүмүүсийг Улсын Их Хурлаас шалгаруулж томилно. Ингээд энэ ёс зүй эзэнтэй болох юм байгаа юм. Институтчлэгдэх юм байгаа юм. Учир

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

нь энэ 90-ээд оноос хойш энэ шинэ үе төлөвшиж бойжиход бүх юмыг хуучин ёс зүйн хэм хэмжээ норм стандарт байхгүй болчихсон учраас ерөөсөө ёс зүй гэж хэм хэмжээ гэж хамаагүй, юу дуртайгаа хийж болно, хүний эрх эрх чөлөө гэсэн энэ халхавч доор юу дуртайгаа байж болно гэсэн ийм мораль, стандартгүй, архидан согтуурах, садар самуун, ер нь бүх төрлийн энэ хуулийн зөрчлийн үндэс болсон ёс зүйн зөрчил нийгэмд хавтгайрсан. Үүнийг засах манлайллыг төрийн алба үзүүлэх ёстой юм байгаа юм. Ийм учраас цөөн зарим хүмүүсээс болж төрийн албан хаагчдын нэр хүнд унаж байгаа. Ийм учраас үүнийг засаж залруулъя. Төрийн албан хаагчид өөрөө өөрийгөө цэвэрлэдэг механизм байя. Нийтээрээ төрийн албан хаагчдын манлайллын доор үүнийг засаж залруулъя гэсэн ийм хууль гарч байгаа юм.

Тийм учраас шатыг дээрээс нь эхэлж шүүрдэхийн адил төрийн албанд ёс зүйг хэвшүүлэх ажлыг төрийн өндөр албан тушаалтнууд, дарга удирдлагуудаасаа эхлэн хэрэгжүүлэх хэрэгтэй. Дарга нар хууль зөрчсөн үйлдлийг хийхийг шаарддаг, ажлын байрны дарамт үзүүлдэг, ёс бус буруу зүйл рүү албан тушаалаараа далимдуулан уруу татан оруулдаг байдал энэ хуулиар арилах учиртай. Ийм шаардлага тавьж байвал Ёс зүйн зөвлөлдөө энгийн албан тушаалтнууд мэдээлдэг болох ёстой. Ингэж байж төр цэвэршинэ, төрийн нэр хүнд өргөгдөнө. Энэ хуулийн дагуу Ёс зүйн хороо бол төрийн болон орон нутгийн байгууллагуудын дэргэд Ёс зүйн дэд хороо байгуулагдаж ажиллана. Засгийн газрын дэргэд Ёс зүйн хороо ажиллана. Бүх сайд нарын үйл ажиллагаандаа иргэдийн санал гомдлоор энэ ёс зүйн хяналт тавина. Ингээд Ёс зүйн хороод нэг талаасаа төрийн албан хаагчдыг даргаас хамгаалдаг хамгаалалт болно.

Иймд Төрийн албаны зөвлөл болон Засгийн газар, Ёс зүйн хороодыг шуурхай байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангаж

ажиллах шаардлагатай. Ийм учраас эцсийн хэлэлцүүлэг дээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо энэ хуулийг хэрэгжүүлэх Улсын Их Хурлын тогтоол батлах шаардлагатай. Авлигаас ангид байж, бүх шатад ёс зүйтэй төрийн албыг бүрдүүлснээр төрд итгэх иргэдийн итгэлийг бүрдүүлэх боломж бүрдэнэ. Ингэж байж л Монгол төрийн мэлхий тунгалаг, өлмий бат оршиж, төрийн түшээдийн нэр хүнд сэргэнэ. Ийм учраас энэ Төрийн албаны ёс зүйн тухай хууль бол маш сайн институц механизм бүрдүүлж байгаа, эрүүл саруул нийгэм бүрдүүлэх их үндэс болох юм шүү гэдгийг бас онцлон тэмдэглэж хэлэхийг хүсэж байна.

Нөлөөлж л болохгүй. Түүнээс үнэхээр чадвараараа зээлээ авна уу, шаардлагаараа тэр ажилд томилогдоод ажиллах нь хэнбугай нь ч бололцоотой. Харин нөлөөлж, дарамт учруулах замаар энэ аливаа үйл ажиллагаа явуулахыг таслан зогсоосон ийм механизм бүрдүүлж байгаа ийм ач холбогдолтой хууль гэдгийг онцлон дэмжихийг хэлэхийг хүсэж байна.

Ингээд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд хуулиа хэрэгжүүлэх талаар дагаж мөрдөх журмын тухай хууль, тогтоолыг эцсийн хэлэлцүүлэгтээ санаачлахыг чиглэл болгож байна. Байнгын хорооны дарга Баттөмөр гишүүн, ажлын хэсгийн гишүүдэд баярлалаа.

15.49 цаг

Ингээд дараагийн асуудалд орно. Боловсролын хууль дуусаагүй байна, болохоо больсон.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 04 сарын 27-ны, 28-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай асуудлыг хэлэлцээд, чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж, олонхын дэмжлэг авсан саналуудыг хуулийн төсөлд нэмж тусган, төслийн агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй завсруудыг хийлээ.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 15 зарчмын зөрөөтэй санал мөн хуулийн төслийн зарим зүйл заалтыг дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 17 зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийг

3-ны 2-оос дээш хувийн саналаар тус тус дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрөөтэй саналуудыг төсөлд нэмж тусгасан эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томъёоллуудыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Аялал жуулчлалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналуудыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхэн хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

“Парламентын боловсрол” хөтөлбөрт хамрагдаж буй Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн 12-ын Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт сурагчид та бүхэндээ сурлага, хөдөлмөр, спортын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөгөөд, сурах чиглэлийг эрхэм болговол хандах зөв чинь өөрөө тогтоно. Мэдлэг, туршлага, дадал гурав бол амжилтын үндэс юм шүү гэдгийг онцлон тэмдэглэе. Амжилт хүсье, та бүхэнд. Сур сур бас дахин сур гээд үү. Тийм. Сурах чиглэлийг эрхэм болговол хандах цэг өөрөө тогтоно гэж.

Ингээд баярлалаа.

Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Аялал жуулчлалын бодлогын газрын дарга Төгсгэрэлийн Мөнх-Од, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах шинжээч Нармандахын Жамъянхүү, “Монголын эрх зүй судалгааны хөгжлийн төв” ТББ-ын хуульч, судлаач Ренчинпүрэвийн Лхагвабаяр, Хөвсгөл аймгийн Засаг даргын Аялал жуулчлалын зөвлөх Олдохын Мөнхнасан, Лүүк Монголия ХХК-ийн захирал Төмөрдашийн Баттулга.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүнээр тасаллаа.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн асуулт асууна.

Ж. Чинбүрэн: Баярлалаа. Хуулийн хэлэлцүүлгийн явцад найруулгын өөрчлөлт оруулаад тэгээд энэ аялал жуулчлалын чиглэл дотор эрүүл мэндийн салбарыг оруулна гэж тохирлоо гэж би ойлгосон. Тэгээд энэ асуудал орж ирсэн үү? Орж ирээгүй бол яагаад орж ирээгүй вэ гэж асууя.

Тэгээд бид нэг энэ эрүүл мэндийн чиглэлээр Монголоос гадагшаа урсаж байгаа мөнгөний урсгалаа зогсоох гээд үзээд байдаг. Тэгэхэд бид өөрсдөө үүнийг хөгжүүлж гэж бодохгүй байна гэдэг бол энэ бодлогыг ерөөсөө л дэмжиж байгаа л гэж харагдахаар болж байна.

2-т, Монгол Улсын уламжлалт анагаах ухаанд өөр газарт байдаггүй маш олон уламжлалт анагаах ухааны эмчилгээнүүд байна. Хануур, төөнүүрээс авхуулаад. Дээрээс нь байгалийн элсэн рашаан ч гэлтэй сувилал рашаанууд байж байна. Энэ гаднаас Монголыг зориод ирье гэсэн энэ бодлогодоо үүнийг оруулчихъя гэдгийг хэдүүлээ ярьж тохирлоо гэж би ойлгосон. Тэгээд энэ асуудал орохгүй байгаад байгаа нь ямар бодлоготой юм бэ?

Ер нь судалгаанаас харахад 1 эрүүл мэндийн аялал жуулчлалаар явж байгаа жуулчин 6.8 мянган доллар зарцуулдаг. Зүгээр явган аялал хийж байгаа жуулчин бол бараг 200 доллар ч зарцуулахгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ том бодлогыг энэ Монгол руу урсах энэ мөнгөний бодлогыг яагаад дэмжихгүй байгаа юм бэ? Энэ асуудлыг оруулж ирнэ гэж уг нь ярьсан даа. Энэ дээр хариулт авъя.

Г.Занданшатар: Асуултад хэн хариулах вэ? Хассуурийн Ганхуяг гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулъя, асуултад.

Х.Ганхуяг: Тийм. Ер нь Чинбүрэн гишүүн маш ийм зөв юм яриад байгаа юм. Тэгээд уг нь оруулчихъя гэхээр оруулчихаар ингээд яг бүр бүх төрлийн аялал жуулчлалыг ингээд төрөл болгоноор нь оруулах шаардлага үүсчхээд байгаа юм л даа. Тэгэхээр аягүй олон дахиад саналууд гарч ирнэ. Тэгээд ингээд төрөл болгоныг нь оруулаад яваад байхаар бас нэг жоохон учир дутагдалтай болчихоод байгаа юм. Ерөнхийд нь оруулчихсан байгаа гэж ойлгож болно. Салбарын яам яг энэ тал

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дээр нь онцгой ач холболт өгөөд яг бодлогоор дэмжээд явчихна гээд ярьж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар:

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн тодруулъя, тодруулж асууна.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр нөгөө үндсэн чиглэл оруулна гэдэг бол ер нь энэ тусгайлан тухайн салбаруудыг онцгойлон анхаарна л гэсэн ийм санаа орж байгаа гэж би ойлгоод байгаа юм. Тэгээд хуульдаа бүр ингэж оруулж өгч, зориудаар аялал жуулчлалаа тэр дотроо эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлэх энэ бодлогоо хэрэгжүүлэхэд тус дэм болно л гэж харж байгаа. Тийм учраас, зүгээр олон юм барьцана энэ тэр гэдэг тайлбар биш байх, Ганхуяг гишүүн ээ, энэ ажлын хэсгийг ахалж байгаа хүний хувьд энэ эрүүл мэндийн салбарын аялал жуулчлал гэдгийг бүр зориуд сөрж оруулж манай Монголын зах зээлээс бараг зөвхөн хорт хавдар, зүрх судасны өвчнөөр гэхэд л 90 сая доллар жилдээ гарч байгаа шүү дээ. Энэ урсгалыг зогсоох бодлогоо бид хийх энэ асуудлаа л энд оруулж ирж байгаа том геополитикийн асуудал гэж харж байна.

Өнөөдөр эрүүл мэндийн салбарыг муулж, эмчилж чаддаггүй, оношилж чаддаггүй гэдэг өгүүлбэрээр эрүүл мэндийн салбарт итгэх итгэлийг буулгаж, гадагшаа урсах урсгалыг улам нэмүүлж байгаа юм. Тэгэхэд хөөрхий энэ эрүүл мэндийн салбарынхан чинь өөрснөө чаддаг, хийдэг гэж харуулах гээд хичээгээд зүтгээд байхад нь нэг ганц өгүүлбэрээс айж ичээд байх ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсэг Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд хариулна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд хариулна.

Чинбүрэн гишүүний асуултад хариулъя, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд. Бид нар ярьсан юм.

Тэгээд юу гэж ярьсан бэ гэхээр 4.1.8 дээр тусгай сонирхлын аялал жуулчлал гэж тусгай мэргэжлийн ур чадвар, техник хэрэгсэл шаардсан аялал жуулчлалыг гэдэг хэсэг рүү оруулаад, яг эмнэлгийн үйлчилгээ эрүүл мэндийн аялал жуулчлалтай холбоо бүхий асуудал дотроо бас нэлээн олон төрөлд ангилагдаж байгаа учраас мэргэжлийн ур чадвар шаардаж байгаа учраас 21.1.2 дээр тусгай сонирхлын аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах журмыг аялал жуулчлалын талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх дотор нь бас ингээд оруулаад өгчихсөн юм. Яах вэ, зүгээр 5.3.3 дээр эрүүл мэндийн аялал жуулчлал, спортын аялал жуулчлал гэдэгтэй адилхан хэмжээгээр эрүүл мэнд гээд үг нэмчхэж болж байгаа. Эрүүл мэнд, спортын арга хэмжээ, үзмэр болон урлаг, соёлын, бусад үйлчилгээ гээд. Тэгэхээр энэ өөрөө нөгөө журамлагдахгүй 1 дүгээрт, нарийвчилсан харилцааг заахгүй.

2 дугаарт, мэргэжлийн ур чадвар шаардахгүй гэдэг утга агуулгынх нь хүрээнд ярилцаж, ярилцаж байгаад л тусгай сонирхлын аялал жуулчлал гэдгээрээ тусгай мэргэжлийн ур чадвар шаардахаар тусдаа журамласан хэлбэрээрээ зохицуулалтыг хийгээд явчихъя гэдэг ийм утга агуулгыг л ажлын хэсэг дээр хөндөж ярьж эцэслэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Тусгай зориулалтын аялал жуулчлал нь тусдаа явах юм байна. Тэр ангийн тухай хуулиа буцаасан зүйл гээд л хүмүүс.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томьёоллоор санал хураана.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо давхар хуралдаад санал хураалт явуулаад байна.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Зочид танилцуулъя. Санал хураалтад бэлтгээрэй. Зарчмын зөрөөтэй 27 санал байгаа. Санал хураалт явуулна.

Түүний өмнө зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэнгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Глобал инновац” сургуулийн 12-ын А, 12-ын Б ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт сурагчид та бүхэндээ сурлагын өндөр амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөгөөд сурах чиглэлийг эрхэм болговол хандах зүг чинь өөрөө тогтоно шүү. Сайн суралцаж, сургуулиа амжилттай төгсөж, мэргэжлээ зөв сонгохыг хүсэн ерөөе.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулна.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт явуулъя.

Гишүүд, Ховдын гишүүд байрандаа сууя. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн суудалдаа сууя, санал хураалтад бэлтгэе. Боловсролын байнгын хороог завсарлуулах уу. Санал хураалтаа явуулъя.

Эрхэм гишүүн Сүхбаатарын Батболд ирсэн тул санал хураалтыг эхлэхэд бэлэн боллоо. Баагаагийн Баттөмөр, Хүрэлбаатарын Булгантуяа нарын гишүүд гаднаас орж ирье. Санал хураалт.

22 гишүүн дэмжиж 51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ, Ганбат, Болдын Жавхлан, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Раднаасэд, Тэмүүлэн, Ундрам, Цогтгэрэл, Чинбүрэн, Энх-Амгалан, Нямаагийн Энхболд, Чинбүрэн, Б.Энх-Амгалан 2 гишүүн эсрэг гараад байна шүү.

2.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Хөтөч” гэсний өмнө “Аялал жуулчлалын мэргэжилтэй, эсхүл” гэж, мөн зүйлийн 10.2.2 дахь заалтын “үндэсний” гэсний өмнө “хууль тогтоомж,” гэж, 10.3 дахь хэсгийн “журмыг” гэсний өмнө, 10.4 дэх хэсгийн “чиг үүргийг” гэсний өмнө “болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох” гэж тус тус нэмж, мөн 10.4 дэх заалтын “журмын дагуу” гэснийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

Энэ эх хуулийг нь аваад ир дээ. Морь унуулах, тэмээ унуулах үйлчилгээний хөтөч гээд л бас заачихсан байгаа юм даа, түүнийгээ тэгээд.

58.5 хувийн санал санагдсан.

3.Төслийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2 дахь хэсэг нэмэх:

“10.2.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэхэд энэ хуулийн 10.1-д заасан шаардлага хамаарахгүй.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

Энэ 10 дугаар зүйлийг тэр чигээр нь үлдээчихсэн байх чинь.

61 хувь.

Тэр 10.5 дээр байгаа ан, морьд юу морь, тэмээ унуулах хөтөч гэж байгаа шүү дээ. Тэгээд тэр чинь тэгээд яаж аялал жуулчлалын үнэмлэх аваад тэгээд

1 ийм хүндрүүлээд байна гээд байхад улам хүндрүүлчихсэн байх юм.

5. Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Харин 4 гэж байна шүү дээ. Битгий тасалдуулаад бай л даа чи.

4.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Даатгал

15.1.Тур оператор, аяллын агент нь үйл ажиллагаандаа алдаа гаргасны улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

15.2.Өндөр уулын авиралт, спорт агнуур, олзворын ан, усны гүнд шумбах, авто спорт, нисдэг тэрэгний аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулна.

15.3. 15.2-т зааснаас бусад эрсдэл бүхий аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд даатгуулж болно.

15.4.Энэ хуулийн 15.2-т заасан даатгалд хамруулах үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллага хариуцан зохион байгуулна.

15.5.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “хамгаалах, байгаль, түүх, соёлын өвийг” гэснийг “байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг” гэж, 19.5 дахь хэсгийн “мөрдөгдөх техникийн зохицуулалтад нийцсэн газар зохион байгуулалтын болон” гэснийг “аялал жуулчлалын үйл ажиллагаа, газар ашиглалтад холбогдох техникийн зохицуулалт, стандартыг мөрдөх бөгөөд түүнд нийцсэн” гэж, 19.7 дахь хэсгийн “газар зохион байгуулалтын нэгдсэн санд” гэснийг “газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд” гэж, 19.9 дэх заалтын “аймаг, нийслэлийн асуудал” гэснийг “аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал” гэж, мөн 19 дүгээр зүйлийг 16 дугаар зүйл болгон тус тус өөрчилж, 19.12 дахь хэсгийн “газар нутгийн” гэснийг, 19.6 дахь хэсгийн “газар зохион байгуулалтын болон” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19.8.Орон нутгийн аялал жуулчлалын бүс нь менежментийн төлөвлөгөөтэй байна. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалтын асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.9 дэх хэсэг нэмэх:

“19.9.Улсын аялал жуулчлалын бүсэд хамаарах аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

төлөвлөгөөнд аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 19.5-д заасан техникийн зохицуулалт, стандартыг мөрдөнө.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уул нь тэр 10.5 дахь тэр усанд шумбах, морь унуулах энэ тэр чинь хөтчөөс гадна мэргэжлийн багш, сургагч зааварлагчтай байна гээд ингээд тэр нь хөтөчтэй байна гэсэн санаа байгаад байхгүй юу. Тэгээд тэр морь унуулдаг хөтөч чинь малчид заавал үнэмлэх авах, заавал сургалтад хамрагдах тийм л нөхцөлийг анзаараач гэсэн тэгээд тэр чигээр нь бүр хүндрүүлээд оруулчих юм. Дараа нь баахан хүнд суртал, чирэгдэл гарна даа. Баахан үнэмлэх олгох гэсэн юм.

8.Төслийн 19 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 19.15 дахь хэсэг нэмэх:

“19.15.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа эрхлэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч хоорондын орон зайн төлөвлөлтөд холбогдох техникийн зохицуулалт, стандартыг заавал дагаж мөрдөнө.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Сайд тэр журмаа батлахдаа тэр нэг хөтчийн үнэмлэх олгох юмаа маш энгийн хялбар болгож, аялал жуулчлалын компанид нь өгдөг юм уу, тэгэхгүй тэгээд л яам олгодог болчих юм бол малчин болгон хот ирж үнэмлэх авна гэж байхгүй шүү дээ.

9.Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.13 дахь заалт нэмэх: “

“4.1.13.“Аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөө” гэж аялал жуулчлалын бүсийн байгалийн нөөц, түүх, соёлын дурсгалыг хамгаалах, зохистой ашиглах, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн богино болон дунд хугацааны төлөвлөгөөг.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

Нямаагийн Энхболд гишүүн горимын санал гаргана.

Н.Энхболд: Би уг нь дэмжсэн санал өгсөн юм. Энэ аппарат маань ажиллалгүй буруу гарчхаад байгаа. Та нэг саналыг хүчингүй болгоод, дахиад хураалгаад өгөөч.

Г.Занданшатар: 9 дэх саналыг саяын санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг дахиж явуулъя. Хүчингүйд тооцох санал хураалт.

57.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Сая дахин санал хураалтыг явуулна. Саяын хүчингүй болгосон горимын санал дэмжигдсэн учраас аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөөг тодорхойлсон энэ санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Төслийн 20 дугаар зүйлийг 17 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

17 дугаар зүйл.Отоглох цэг

17.1.Улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай

газар нутагт аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага отоглох цэг байгуулах байршилыг тогтооно.

17.2.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт отоглох цэгийг улсын төсвийн, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны, олон улсын төслийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

17.3.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн менежментийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа хэрэгжүүлэх бөгөөд менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

17.4.Энэ хуулийн 17.1-д заасан улсын аялал жуулчлалын бүс нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцаагүй тохиолдолд тухайн аялал жуулчлалын бүс дэх отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

17.5.Энэ хуулийн 17.4-т заасан отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх этгээдийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна.

17.6.Энэ хуулийн 17.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн үйлчилгээний хураамж авах, зарцуулахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

17.7.Отоглох цэг нь байнгын, эсхүл түр байж болох бөгөөд стандартын шаардлага хангасан байна.

17.8.Отоглох цэгт олон нийтийн аюулгүй байдлыг хангах харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулна.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11. Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11-ийг дахиж санал хураалт зарлаад байхад яагаад явахгүй байна. Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалтыг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

67.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 27 дугаар зүйлийг 26 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

26.1.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн нэгдэл бүхий, ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна.

26.2. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах болон энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

26.3. Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дүрэм, удирдлагын бүтэц, санхүүжилт, зохион байгуулалтын бусад асуудлыг бүх гишүүдийн хурлаар бие даан шийдвэрлэнэ.

26.4. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

64.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 32 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

32.1.Энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах хурлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хууль батлагдсан өдрөөс хойш 90 хоногийн дотор зохион байгуулна.

32.2.Энэ хууль батлагдсан өдрөөс өмнө байгуулагдан аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хамтран энэ хуулийн 26.1-д заасан

нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулна.

32.3.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 32.1-д заасан хуралд оролцох байгууллагыг нээлттэй бүртгэх ба тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зохистой харьцааг хангаж хурлыг зохион байгуулна.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

56.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС” гэж өөрчилж, 13 дугаар зүйлийг 18 дугаар зүйл болгон Гуравдугаар бүлэгт тусгах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн Дөрөвдүгээр бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГА, МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ БҮРЭН ЭРХ” гэж өөрчлөх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

62.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1.5 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “6.5, 20.5,” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “, хэрэгжүүлэх асуудлаар санал гаргах” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Боловсролын хууль тэгээд л маргааши л болох нь дээ. Одоо энэ боловсролын юу дуусахгүй.

18.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.11.аялал жуулчлалын дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх;” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

Бат-Эрдэнэ сайд аа. Энэ аялал жуулчлалын тэр төлөвлөгөө, менежментийн төлөвлөгөө гэдэг дээр тэр аялал жуулчлалын дэд бүтцээ нэг тодорхойлмоор байгаа юм. Тэгэхгүй бол төсөв орж ирэх болгонд л манай аймаг гээд л ингээд, ингээд зарим аймаг руу ингээд л аялал жуулчлалын төсөв тэр чигээрээ явчихдаг. Тэгэхэд чинь олон газар баруун бүс дээрээ Баян-Өлгий аймагт, Баянхонгор аймагт, Шаргалжуут энэ тэр гээд зам дэд бүтцүүд нь хаягдчихсан юмнууд байна. Сангийн яам энэ аялал жуулчлалыг чинь шийдээд байгаа байхгүй юу даа. Ганцхан аймагт аялал жуулчлал хөгжүүлэх гэж байгаа юм шиг хуваарилалт хийж ирээд.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгээд энэ Хөвсгөл, Баянхонгор, Баян-Өлгий гээд аймгуудыг бас ингээд 10 жил хаялаа гэж. Баянхонгорын Шаргалжуут гээд дэлхийд байхгүй юу байна? Одоо хүртэл засмал замгүй, жархан километр аймгийн төвөөс. Дундговийн Их, Бага газрын чулуу энэ тэр гээд л байж байна. Тэгээд үүнийг ингээд аялал жуулчлалын дэд бүтцийн төлөвлөгөө гээд нэг гаргачихсан байгаа юм. Маршрутаар нь зураад ингээд нэг тойрог болгоод аялал жуулчлалын маршрутыг гаргана.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх

зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөх:

“1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.14.Аялал жуулчлалын тухай хууль зөрчих

1.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

1/33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгаль хамгаалал, соёл, аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагаар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахтай холбоотой харилцаанд энэ хуулийн 27.12-т заасан журам үйлчлэхгүй бөгөөд хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж ашиглуулна.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

Тогтохоо дарга аа, та энэ заалтыг хараарай. Таны яриад байсан нь ийм л байна.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2/33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9-д заасан аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, бий болгох зорилгоор газар ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглах эрх олгоход Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-т заасныг үндэслэн сонгон шалгаруулалтыг хялбаршуулсан журмаар энэ хуульд заасны дагуу явуулж болно.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Амьтны тухай хуульд доор дурдсан агуулгатай 29² дүгээр зүйл нэмсүгэй:

1/29² дүгээр зүйл.Тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийн дуудлага худалдаа зохион байгуулах

Энэ чинь заалт хийчихсэн байна шүү дээ, бүр. Амьтан алах дуудлага худалдаа хийх юмыг хуульчилж болдог юм уу. Ямар ч байсан уншчихъя.

29².1.Агнуурын амьтныг тусгай зориулалтаар агнах, барих эрхийг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасны дагуу нээлттэй дуудлага худалдааны журмаар олгох бөгөөд дуудлага худалдааг цахим хэлбэрээр явуулж болно.

29².2.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 26.3-д заасны дагуу гаргасан Засгийн газрын шийдвэр, агнуурын нарийвчилсан төлөвлөгөөг үндэслэн, тусгай зориулалтын ан амьтан агнах, барих тоо хэмжээг аймаг, нийслэл тус бүрээр тогтооно.

29².3.Дуудлага худалдааг тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо хэмжээг баталсан шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор нийтэд мэдээлж, 30 хоногийн дотор аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

29².4.Дуудлага худалдааг явуулах хугацааг товлосон шийдвэрийг дуудлага худалдаа явагдахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө гаргах ба дараах мэдээллийг тусгана:

29².4.1.дуудлага худалдаа явуулах он, сар, өдөр, цаг, хаяг;

29².4.2.тухайн аймагт ноогдох дуудлага худалдаанд оруулах тусгай зориулалтаар агнах, барих амьтны тоо, төрөл зүйлийн жагсаалт;

29².4.3.дуудлага худалдааны босго үнэ, дэнчингийн хэмжээ, төлөх хугацаа;

29².4.4.хуульд заасан бусад.

29².5.Энэ хуулийн 29².4.3.-т заасан дуудлага худалдааны босго үнэ нь тухайн амьтны Засгийн газраас тогтоосон жишиг үнийн 20 хувь байна.

29².6.Дуудлага худалдааны дэнчин нь энэ хуулийн 29².5-д заасан босго үнийн 50 хувь байх бөгөөд дэнчинг дуудлага

худалдаанд оролцохоос 24 цагийн өмнө урьдчилан төлж, бүртгүүлсэн байна.

29².7. Дуудлага худалдаанд ялсан оролцогчийн дэнчинг дуудлага худалдааны үнийн дүнд оролцуулан тооцох ба ялаагүй оролцогчийн дэнчинг 14 хоногийн дотор буцаан олгоно.

29².8. Дуудлага худалдаанд хоёр, түүнээс дээш этгээд оролцох хүсэлтээ ирүүлж, үнийн санал өгсөн тохиолдолд дуудлага худалдааг хүчинтэйд тооцно.

29².9. Дэнчин төлж бүртгүүлсэн этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч дуудлага худалдаанд оролцоно.

29².10. Дуудлага худалдаанд ялсан этгээд нь дуудлага худалдааны үнийг дуудлага худалдаа дууссанаас хойш ажлын таван өдрийн дотор төлнө.

29².11. Дуудлага худалдааны ялагч нь энэ хуулийн 29².10-т заасан хугацаанд дуудлага худалдааны үнийг төлөөгүй тохиолдолд дэнчингээ алдах ба дараагийн өндөр үнийн санал гаргасан этгээдэд санал тавина.

29².12. Дуудлага худалдаанд хоёр, түүнээс дээш оролцогч оролцоогүй, эсхүл үнэ хаялцаагүй, эсхүл энэ хуулийн 29².11-т зааснаар дараагийн өндөр үнийн санал гаргасан оролцогчид тавьсан саналыг хүлээн аваагүй тохиолдолд дуудлага худалдааг хүчингүй болгож, 14 хоногийн дотор хоёр дахь дуудлага худалдааг явуулна.

29².13. Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагч бол тусгай зөвшөөрлийг өөрийн менежмент хариуцдаг агнуурын бүс нутаг дээр бүртгүүлж, баталгаажуулна.

29².14. Дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчаас өөр этгээд бол тухайн аймгийн аль нэг агнуурын бүс нутгийн

менежмент хариуцагчтай ан агнуулах гэрээ байгуулна.

29².15. Аймаг, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдааны төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, хураамжийг төлсөн баримт, энэ хуулийн 29².14-т заасан гэрээг үндэслэн ан агнах тусгай зөвшөөрөл олгоно.

29².16. Энэ хуулийн 29².15-д заасан тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхгүй.

29².17. Дуудлага худалдааны үнийн дүнгийн орлогыг Төсвийн тухай хуулийн 23.7.4, 23.9.4-т заасны дагуу орон нутгийн төсөвт шилжүүлнэ.

29².18. Дуудлага худалдаанаас орсон орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэний дараа үнийн дүнгийн 20 хувийг агнуурын бүс нутгийн амьтны нөөцийг хамгаалах, өсгөн үржүүлэх арга хэмжээнд зориулан менежмент хариуцагчид олгоно.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Үг хэлэх гишүүд Нямаагийн Энхболд, Гочоогийн Ганболд, Жигжидийн Батжаргал гишүүдээр тасаллаа. Үгээ хэлье.

Нямаагийн Энхболд гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга.

Н.Энхболд: Түрүүчийн хэлэлцүүлгийн үеэр ярьж байсан энэ Амьтны тухай хуультай холбоотой заалтууд дээр бүр тусгайлан нэрээр нь тэр, тэр амьтан тэр загас гээд оруулчихсан байна. Тэр нь хасагдчихсан байгаа юм байна. Тэгээд энэ дээр агнах барих тухай зөвшөөрлийн тухай ярьж байна. Өөр үг ороогүй байна. Тэгэхээр миний ойлгосноор би бас санал болгож байсан, энд загас ороогүй гэж бодож саналаа өглөө шүү гэдгийг протоколд зориуд тусгая. Энэ дараа нь хууль мөрдөх үед буруу зөвийг нь ялгахад протокол

үзэх ёстой. Тэгээд би зориуд энд ингэж ойлгогдож хураагдлаа шүү гэдгээ хэлж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Тэгээд загасыг ам биш гэж үзэх юм уу, тийм ээ. Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Би үүнийг түрүүчийн хэлэлцүүлэг дээр яг энэ ан амьтны тухай хуулийн энэ хэсгийг би буцаасан гэж ойлгоод байгаа юм. Гүйцээн боловсруулах чиглэл өгөөгүй гэж ойлгож байгаа юм. Тэгэхдээ үүнийг зүгээр яах вэ, би дуудлага худалдааг нь зөвшөөрч байгаа юм. Дуудлага худалдаа болно. Тэгэхдээ энэ дээр ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүй хэн ч авч болно гэдэг энэ өөрөө буруу. Яагаад гэхээр энэ чинь буу, шийдэм хэрэглэнэ, эрсдэл өндөртэй.

2 дугаарт нь, тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд нь зүгээр яах вэ, амьдрал дээр харж байхад нэг цас зуд, ган гачиг болсон ч гэсэн энэ нэг ан амьтдаа хамгаалаад, нэг өвс тэжээл, хужир шүү тавьж өгөөд, нутаг оронд нь нэг отго байгуулаад ингээд хамгаалалцаад явдаг л ийм зүйл л дээ. Тэгэхээр дуудлага худалдаанд хэн хамаагүй хүн орно гэдэг бол энэ өөрөө их буруу болоод байна, 1 дүгээрт. Тэгэхээр ядаж нэг тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд тэр тусгай зөвшөөрлийн журмынх нь дагуу олгоно л биз. Хэдэн ч хүн авсан хамаагүй, тэр зөвшөөрөлтэй хүмүүсийн дунд дуудлага худалдаа хийдэг хэлбэр лүү оруулбал зүгээр юм биш үү.

Энэ дээр 29-ийн штрих 2-ын 11, 12 бол энэ ноцтой том алдаа явж байна шүү дээ. Эхний дуудлага худалдааны хамгийн өндөр үнэ хэлсэн нөхөр авахгүй бол 2 дахь нь авна гэж байна. Тэгэхээр энэ чинь нөгөө дээр үеийн нөгөө нэг завхрал явна шүү дээ. Хамгийн өндөр үнэ нь 200 сая гээд хэлчихнэ. 2 дахь нөхөр нь 10 сая гэгчихнэ шүү дээ. 10 сая гэнгүүт нь шууд хоёр, 300 сая гэгчихнэ. Тэгээд нөгөө нөхөр нь 300 саяыг хэлсэн хүн нь авахгүй яваад өгөхөөр зэрэг 2 дахь хүн нь авах нь

л дээ. Яг тийм үг өгүүлбэрээр байна шүү, энэ. Энэ заалтаар орох юм бол энэ өөрөө ёстой балай юм болно шүү дээ. Хуйвалдаж орно, зохион байгуулалттай ороод эхний үнийг дөнгөж нэг босго үнийг нь нэмэнгүүт нөгөөдөх нь хамгийн дээд талынх нь үнийг хэлнэ. Тэгэхээр энэ 2 заалт ер нь өөр болохгүй байна. Тэгэхээр энэ дээр ерөөсөө хэн хамаагүй ордог ийм одоо зүйлийг ядаж энэ тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн дунд нь дуудлага худалдаа явуулдаг ийм л хэлбэр лүү орохгүй бол болохгүй дээ. Энэ дээр ажлын хэсгийнхэн ямар байр суурьтай байгаа юм.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн. Тэгээд Хассуурийн Ганхуяг гишүүнээр тасалъя.

Ж.Батжаргал: Тийм ээ, энэ агнуурын асуудлыг дуудлага худалдаагаар хийх тухай асуудал яригдаад байгаа юм. Уул нь экологи, эдийн засгийн үнэлгээ гэж нэг үнэлгээ байгаад байгаа. Тэгээд наад босго үнэ чинь нэг бол 20 энэ тэр гээд ингээд өнөө экологи, эдийн засгийн үнэлгээнийхээ 20 хувиар тогтох гээд. Тэгээд үүний чинь зохион байгуулж явуулдаг хүрээлэл нь их бага, тэгээд үндсэндээ экологи эдийн засгийнхаа үнэлгээ рүү дөхөхөөргүй л юм болж л хувираад байна шүү дээ. Нэг талаасаа харахаар.

Нөгөө талаасаа энэ байгалийн бүхий л баялгуудын өнөө төлбөрийн тухай хуулиар орж ирсэн орлогын тэдэн хувийг буцаагаад хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна гэдэг өнөө хуулийн заалттайгаа энэ яаж нийцээд байгаа юм бэ. 20 хувийг нь тэр менежментийн үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа нөхдөд өгөхөөр дуудлага худалдаагаар орж ирсэн орлогын ийм юм яригдаад байх юм. Гэтэл уул нь тэр төлбөрийн тухай хуулиар нь ой дээр бол ийм ийм, усан дээр ийм ийм, ан амьтан дээр иймийг нь буцааж зарцуулна гэдэг тэр хуультайгаа яаж нийцээд байгаа юм бэ гэдэг асуудал.

3 дахь зүйл. Ерөөсөө энэ агнуурын бүс нутгийг тогтвортой байлгах үүднээс бас мэргэжлийн байгууллагууд олон жил энд нэлээн тийм хамгаалалт, тордолт юмнууд хийгээд уг нөөцөө бий болгоод явчихсан ийм үйл явц. Одоо үүнийгээ яаж цааш нь яг энэ чиглэлээр нь авч явна гэж тооцож харж, ийм заалт аялал жуулчлалын тухай хуулийг дагуулаад энэ хуульдаа оруулаад ирэв ээ. Ийм 3 зүйлийг их тодорхой хариулт авахгүй бол болохгүй байна.

Г.Занданшатар: Энэ саналууд л хэлнэ л дээ. Хассуурийн Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Ажлын хэсгээс нэмээд хариулчхаарай. Ганболд гишүүний асууж байгаа асуулт дээр энэ 29-ийн итрих 2-ын 14 дээр дуудлага худалдааны ялагч нь агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчаас өөр этгээд бол тухайн аймгийн аль нэг агнуурын бүс нутгийн менежмент хариуцагчтай ан агнуулах гэрээгээ байгуулна гэсэн үг. Нэг ёсондоо дуудлага худалдаанд орлоо. Тэр нөгөө ан агнах тэр зөвшөөрлөө ингээд тэр дуудлага худалдаагаар авчихсан тохиолдолд тэр бүс нутагт байгаа менежмент хийдэг тэр ААН юм уу, хуулийн этгээдтэй гэрээ хийнэ гэсэн үг. Тэгээд тэр гэрээний үндсэн дээр тэр тэр ангийнхаа асуудлыг хийгээд явна гэсэн үг байхгүй юу. Тэгэхээр энэ хараа хяналтгүйгээр гүйж очоод ингээд дуртай газраа буудаад явна гэсэн үг огтоос биш шүү. Тэгэхээр энэ хамтарч ажиллах юуг нь оруулаад өгчихсөн байгаа юм.

Мөн Батжаргал гишүүн, Ганболд гишүүн 2-ын тэр санаа зовниод байгаа асуудал энэ дуудлага худалдаанаас орлосон орлогын 20 хувийг буцаагаад тэр бүс нутгийн амьтны нөөцийг хамгаалах, өсгөн хөгжүүлэх зорилгоор зарцуулах юм байгаа юм. Зарцуулах юм байгаа юм. Яагаад энэ дээр энэ чөлөөтэй ингээд олон хүн оролцох боломжийг нь нээж өгч байгаа вэ гэхээр энэ хуучин угаасаа монопольчлогдсон байсан салбар байхгүй юу. Нэг 9-11 ААН, хуулийн этгээд л энэ

ангийн үйл ажиллагааг явуулдаг. 24, 5 мянган доллароор зөвшөөрлийг нь аваад л тэгээд л цаашаа жуулчдад 100 мянган долларт зараад явчихдаг. Ийм асуудал байсныг өнөөдөр бид нар энд шилэн болгоод, төсөвт илүү их мөнгө оруулдаг болгох, мөн аймаг, сумын төсөвт нь илүү их мөнгө оруулдаг болгох, эргээд тэр 20 хувиараа буюу тэр энэ менежмент хариуцаж байгаа эргээд тэр ан амьтнаа хамгаалах зорилгоор нь илүү зарцуулдаг болно л гэсэн үг. Тэгээд энэ дээр ямар нэгэн алдаатай юм ерөөсөө олж харахгүй байгаа. Тэгээд хэн Бат-Эрдэнэ сайд нэмээд хариулчих уу? Энэ чинь угаасаа дуудлага худалдааны л зарчим шүү дээ. Тэгээд угаасаа л өндөр үнэ хэлээд л тэр өндөр. Бат-Эрдэнэ сайд нэмээд хариулчих. Хэд билээ, 88, 80, дарга аа.

Г.Занданшатар: Энэ асуулт хариултын тэмцээн биш л дээ. Эцсийн хэлэлцүүлэг дээр орж ирээд ингээд дэмжсэн, дэмжээгүй үг л хэлнэ.

Тэгээд энэ аялал жуулчлалын хуулийг дагаад яг амьтны тухай хуульд ийм том заалт оруулах нь ер нь дэгийн хууль, зарчимтай нийцэхгүй л дээ. Үүнийг буцаагаад тэгээд энэ амьтны экологи, эдийн засгийн үнэлгээ гэж тусдаа. Ан агнуур гэдэг тусдаа, спорт агнуур гэдэг тусдаа, амьтны экологийн тэр ан агнуурын менежментийн төлөвлөгөө гэж тусдаа. Тэр амьтны тухай хууль чинь тусдаа зохицуулалттай асуудлыг шууд аялал жуулчлалаар ан агнуулж, мөнгө олох гэж байгаа юм шиг ийм сэтгэл зүй нийгэмд төрүүлээд, тэгээд энэ агнуурын зохион байгуулалтын ажил энэ тэрийг аялал жуулчлалтай яаж холбогдуулах нь гэдэг тодорхойгүйгээр яг ийм зохицуулалт хийх нь үгүй ядаж энэ байгаль хамгаалагчдын эсэргүүцэлтэй тулах. Энэ ядаж байгаль хамгаалагчид, амьтан хамгаалагчид энэ хэлэлцүүлэг хийгдэж энэ тэрээр орж ирэхгүй бол ингээд гуя дагуулж хүзүү гэдэг шиг явж байснаа хүзүү дагуулаад гуя болгоод ингээд ийм хууль шинээр батлаад явчих

юм бол энэ маш сөрөг үр дагавартай. Энэ тэгээд амьтныг мөнгөөр алуулах хууль баталж байна гэсэн ийм асуудал гарна шүү дээ гэнэт.

Дуудлага худалдаагаар гэж байгаа л даа. Тэгэхдээ яг ингэж ийм том нэг санал хураалтаар ийм юм шийдэх нь дэгийн хуульд нийцэхгүй байна. Үүнийг ингээд гүйцээн боловсруулах чиглэл өгөөд, засаж янзлах хэрэгтэй.

Үүнийг Зөвшөөрлийн тухай хууль болон Ан амьтны тухай хуулиар тусдаа өргөн барьж зохицуулна. Аялал жуулчлалын харилцаатай үүнийг хольж хутгаж, ан агнуурыг ан агнуурын аялал жуулчлалаа тусдаа гаргаж зохион байгуулахгүй бол энэ өөрөө цаанаа энэ загас орохгүй гэж хэлж чадахгүй. Цаад хуулиараа ан агнуур түүхий эдийг нь ашиглаж байгаа бүх зүйлийг ан агнуурт гэж орж байгаа юм. Хуульдаа ан гэж амьтны тухай хуульдаа түүхий эд, нөөцийг нь ашиглах зорилгоор олборлож байгаа. Спорт агнуур гэхээрээ тэр эд эрхтнээр нь сорчилж сонгохгүйгээр нийтэд нь агнуурыг гээд ингээд заачихсан учраас наадах чинь тэгээд ингээд шонхор шувуунаас авхуулаад наад бүх ажил чинь нэг тийм сонин энэ хуулиар зохицуулагдах. Тэгээд нөгөө талаасаа нэлээн тийм харгис хууль нийгэмд сонсогдоно.

Аялал жуулчлалыг ингээд нэг. Тэгээд энэ дээр ийм тэр монополыг нь задлаад энэ зөв болгохоор их сайн зохицуулалтыг найруулахгүй бол ийм олон заалттай шинэ хууль бараг ингэж хийх гээд байна шүү дээ, энэ чинь. Агнуурын, ан агнуурын тухай хууль шүү. Энэ амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж хийх гээд байна шүү дээ.

Энэ асуудал дэгд нийцэхгүй байгаа учраас хойшлуулчихъя. Эдийн засгийн байнгын хорооны референт ийм юмнуудыг хайхраагүй ингээд аягүй олон

тэр жижиг нюансууд их сонин яваад байгаа шүү.

Дараагийн санал хураалт явуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Ингээд бүтэн хуулиараа явчих болж таарах уу, тийм ээ.

Тэгээд энэ шаардлагатай бол ийм харилцааг журмаар зохицуулж болно. Засгийн газар журам батлаад. Хуучин Ан агнуурын тухай хууль гэж байсан. Ан агнуурын журам гэж байсан, ан агнуурын тухай хууль журмаараа зохицуулж болно. Тэгэхгүй бол энэ шууд ингэж. Үүнийг бүхэлд нь ингээд энэ ан агнуурын тухай хуультай харилцаа.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг хасах. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо, санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Агнуурын менежментийн төлөвлөгөө, нөөц, агнуурын нөөц, экологи, эдийн засгийн үнэлгээ гээд олон юмтайгаа харьцуулж шүтэж энэ хуулийн ийм дуудлага худалдаа ч байна уу, тоо хэмжээ тогтоох энэ тэр яахгүй бол зохицуулалт нь хүндрэлтэй болох байх. Ер нь дуудлага худалдаагаар хийх нь зөв. Дуудлага худалдаагаараа хийх нь зүйтэй. Үүнийгээ харин.

Ингээд зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

16.52 цаг

Дараагийн асуудалд орно.

Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох, саналыг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Бямбарагчаагийн Тэлмүүн нааш ир дээ. Чи саяын хууль дээр шивнээд байсан, юу ярьсан. Тэр саналаа хэлчих.

Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох саналыг зөвшилцөх асуудлыг хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг оруулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янгугийн Содбаатар танилцуулна.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсаас гадаадын зарим улсад суугаа Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох саналыг танилцуулж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус үндэслэн:

1. Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг эгүүлэн татах,

2. Монгол Улсаас БНКУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

Шагдарын Батцэцэгийг эгүүлэн татаж, Монгол Улсаас БНКУ-д суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Сэсээрийн Золжаргалыг,

3. Монгол улсаас Япон улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргалыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Япон улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Баярсайханыг,

4. Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогосыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбатыг,

5. Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогосыг тус тус томилох саналыг оруулж байна.

Эгүүлэн татагдаж буй Элчин Дамбийням, Ариунболд, Батжаргал нарын томилолтын хугацаа дууссан. Элчин сайд Сарантогосыг ажлын шаардлагаар сэлгэн ажиллуулах, Элчин сайд Батцэцэгийн томилолтын хугацаа үндсэндээ дууссан тул эгүүлэн татах саналыг тус тус танилцуулж байгаа болно.

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 43 дугаар тогтоолоор Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Афганистан улсын нийслэл Кабул хотод ЭСЯ-ны үйл ажиллагааг сэргээж ажиллуулахаар шийдвэрлэсэн боловч Элчин сайдын яамыг өнөө хүртэл нээгээгүй байна. Гэхдээ тус улсад суух Элчин сайдаар Отгоны Дамбинямыг 2014 онд томилж, түүнд Иран улсыг хавсруулсан бөгөөд өнөөг хүртэл эгүүлэн татах асуудлыг эрх зүйн хувьд эцэслэн шийдвэрлэгдээгүй байсан юм.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Элчин сайд нь Монгол Улсын олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд суугаа болон хавсран суугаа Олон улсын байгууллагадаа Монгол Улсыг төлөөлөн ажиллаж, ашиг сонирхол болон эрхийг хамгаалах, харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэх шаардагдах судалгаа хийх, төр засгийн байгууллагыг мэдээллээр хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, 2 болон олон талын харилцааны асуудлаар яриа хэлэлцээ хийх, гэрээ хэлэлцээр байгуулах, Монгол Улсын иргэн хуулийн этгээдийн хууль, ёсны эрх ашиг сонирхлыг олон улсын эрх зүй, суугаа орны хууль тогтоомжийн дагуу хамгаалж ажилладгаас гадна тэргүүлж буй Элчин сайдын яамныхаа үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байдаг.

Элчин сайдаар томилон ажиллуулахаар нэр дэвшүүлж буй эдгээр албан хаагчид нь төрийн алба, дипломат албанд олон жил ажилласан, мэргэжлийн өндөр ур чадвартай, удирдах ажлын дадлага туршилага, гадаад хэлний мэдлэгтэй, төрийн болон дипломат албаны хууль тогтоомжийн шалгуурыг бүрэн хангасан гэж Монгол Улсын Ерөнхийлөгч үзэж байгаа болно.

Иймд асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын дарга Нямаагийн Энхболд танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны

тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсаас БНКУ-д суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Сэсээрийн Золжаргал, Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайдаар Банзрагчийн Баярсайхан, Монгол Улсаас БНСУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбат, Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Эрдэнэцогтын Сарантогос нарыг томилох, Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийням, Монгол Улсаас БНКУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэг, Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргал, Монгол Улсаас БНСУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогос, Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболд нарыг эгүүлэн татах саналыг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 23 оны 5 сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад улсад суух зарим Элчин сайд нарыг томилохоор оруулж ирсэн саналыг дэмжиж байгаагаа илэрхийлээд, гадаад валютын нөөц хөрөнгө оруулалт буурч байгаа тул гадаад бодлогыг эдийн засагжуулах ажлыг эрчимжүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхболд дайн, геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалж том гүрнүүд, холбоотон, түнш улстайгаа хамтран ажиллах бодлогодоо өөрчлөлт оруулж байгаа тул тухайн улс орон гадаад бодлогодоо ямар байр суурьтай байна гэдэгт мэргэжлийн үүднээс хандах, холбогдох яам,

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

иргэдтэйгээ нягт хамтран ажиллах шаардлагатай болохыг нэр дэвшигчдэд анхааруулсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн С.Батболд Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд тодорхойлсон үндсэн зорилтын хүрээнд эдийн засгийн хамтын ажиллагаа гадаад худалдааг болон эрчимжүүлэх, БНСУ-тай харилцан ярилцаж байгаад визний асуудлыг урагшлуулах, Канад Улстай уул уурхай, хөдөө аж ахуйн чиглэлээр урт болон дунд хугацаанд хамтран ажиллах суурь нь тавигдсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, цаашид эрчимжүүлэх нь зүйтэй болохыг онцлон тэмдэглэлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн Сэсээрийн Золжаргалыг Бүгд Монгол Улсаас БНКУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Банзрагчийн Баярсайханыг Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Батнямын Энхбатыг Монгол Улсаас БНСУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар, Эрдэнэцогтын Сарантогосыг Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тус тус томилохыг Байнгын хорооны хуралдаанд оруулсан гишүүдийн олонх дэмжсэн болно.

Түүнчлэн Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийням, Монгол Улсаас БНКУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэг, Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргал, Монгол Улсаас БНСУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогос, Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболд нарыг эгүүлэн татах саналыг Байнгын хорооны

хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох саналыг зөвшилцсөн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хоршоодын дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ ажлын өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Хоршоолол дээр цахилгаанжуулалтыг нэмбэл хөдөөд эжинхэнэ хөгжил цэцэглэлт ирнэ гэж нэг хүн хэлсэн удаатай. Тийм учраас ингээд хоршоолж хөгжиж байж л хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлээ сайжруулна. Хөдөө аж ахуйн түүхий эд үнэд орно, арьс шир, үс ноосоо боловсруулдаг болно. Тийм учраас та бүхний үйл ажиллагааг төрийн бодлогоор дэмжих ёстой. Манай хоршоодын холбооны дарга энд сууж байна. Бас баяр хүргэх байх, Тогтохсүрэн дарга. Тэгээд та бүхэндээ хоршоолох хоршооллын эрхэм ажил үйлсэд чинь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Хоршооллын өмч бол нийтийн өмч юм байгаа юм. Олны тусын тулд хийдэг ажил.

Ингээд ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Янугийн Содбаатар, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг, Гадаад харилцааны дэд сайд Гомбосүрэнгийн Амартүвшин, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Нямдоржийн Анхбаяр, Төрийн захиргаа, удирдлагын газрын дэд захирал Дашипүрэвийн Амарсайхан, нэр дэвшигчид Сэсээрийн Золжаргал Монгол Улсаас БНКУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар нэр дэвшигч, Банзрагчийн Баярсайхан Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар нэр дэвшигч, Монгол Улсаас БНСУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар нэр дэвшигч Батнямын Энхбат, Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар нэр дэвшигч Эрдэнэцогтын Сарантогос.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн. Ширнэнбаньдын Адьшаа гишүүнээр тасаллаа.

Дандаа ингээд юм асууж байгаад хоцорч байх юм. Бөхчулууны Пүрэвдорж гишүүнийг нэм. Материал өгчихсөн байгаа шүү дээ. Цонх цонхоор. Бөхчулууны Пүрэвдорж гишүүнийг нэмлээ. Тогмидын Доржханд гишүүн үг хэлнэ. Асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Яах вэ, ярьж болох уу? Ямар ч байсан энэ орж ирж байгаа нэр дэвшигчдийг дэмжиж байна. Ялангуяа энэ Япон, Солонгост нэр дэвшиж байгаа энэ нэр дэвшигчдийг дэмжиж байна. Яагаад вэ гээд тэгэхээр нөгөө Азийн соёл өөр байдаг. Өөрөөр хэлэх юм бол нөгөө эмэгтэй Элчин сайд байх, эрэгтэй элчин сайд байхын ялгаа бас байдаг юм байна лээ шүү. Тэгээд тэр агуулгаараа нөгөө Солонгост байгаа Элчин сайдыг Канад руу бас сэлгэн хуваарилж байгааг бас дэмжиж байна. Өөрөөр хэлэх юм бол энэ нөгөө ажил

хэрэгч байх талаасаа тийм, эсрэгээрээ харин Европын орнууд руу барууны орнууд руу эмэгтэй нэр дэвшигчдийг явуулах тал нь тэгээд баримтлаад явах нь зүйтэй юм. Ялангуяа Европын орнууд руу эмэгтэй элчин сайдуудыг томилмоор байгаа юм шүү, Батцэцэг сайд аа. Энэ нөгөө ажил хэрэг явуулахад маш их чухал байдаг юм.

2 дахь зүйл нь юу байна аа гээд. Тэгэхээр 1 зүйл асуумаар байгаа юм. Одоо ингээд Элчин сайд нар маань ингээд томилогдлоо. Тэгэхдээ нөгөө нэг гадаад харилцаагаа ярьдаг, нэг сайхан ерөнхий улс төрийн юм ярьдаг нэг ийм байдал чинь дэлхий даяар байхгүй болчихсон байна. Илүү нөгөө прагматик бодлого руугаа явдаг. Тэгээд гадаад, нөгөө элчин сайдууд, дипломат албаны төлөөлөгч нарын гол зорилго нь болохоор яаж эдийн засгийн хамтын ажиллагаа хийх вэ, яаж улс руугаа хөрөнгө оруулалт татах вэ, яаж тухайн улсын зах зээлийг өөрийнхөө орны бизнесүүдэд нээх вэ, яаж жуулчдын тоог нэмэгдүүлэх вэ гэдэг ийм үзүүлэлтүүдээрээ ингээд үндэслээд үр дүнгийн үзүүлэлтүүдийг нь бүр ингээд тавьж байгаад явуулдаг болчихсон юм байна. Сая би нэлээн олон улсын элчин сайдууд Монголд ирээд нөгөө *credentions*-ээ ингээд Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барихад бас уулзсан юм. Тэгээд 1950 оноос хойш нөгөө дэлхийн хүйтэн дайн ингээд дуусчихсан. Одоо нөгөө түүнээс хойш дэлхийн эдийн засгийн дайн яваад байдаг. Тэгээд энэ дээр дипломат албаны нөлөө, үүрэг маш өндөр гээд. Тэгээд эдгээр хүмүүс дипломат албанд хүнээ явуулахдаа хамгийн их тавьдаг шаардлага нь юу вэ гэхээр ерөөсөө л эдийн засгийн хамтын ажиллагаа, ердөө л энэ. Тэгээд ийм байдлаар би бас өмнө нь нөгөө Элчин сайд нарыг оруулж ирж байхад Гадаад харилцааны сайдаас асууж байсан юм. Одоо энэ асуудлаа бас асуумаар байна. Өөрөөр хэлэх юм бол энэ хүмүүс очоод яг ямар үүрэг даалгавартай очих юм бэ? Солонгост маш олон Монголчууд байдаг. Бизнесийн хамтын ажиллагаа хийх бүрэн

боломжтой. Япон Монголын эдийн засгийн харилцаа маш өндөр байдаг. Зөвхөн Жайка, Жибикаас гадна бас Японы хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр яаж ажиллах юм, Канад уул уурхайн орон. Цаашаагаа Монгол Улс уул уурхайн экспорт дээр илүү ажиллах шаардлагатай байдаг. Тэгэхээр хамтын ажиллагаа, техникийн хамтын ажиллагаа яаж явах юм. Ийм байдлаар Элчин сайдуудаас бас өөрсдөөс нь тус бүрээс нь бас байр суурийг нь авмаар байна. Амыг нь авмаар байна. Ямар үр дүнтэй ажиллах юм бэ, үр дүнгээ яг юугаар илэрхийлэх, яаж гаргах юм бэ гэдгийг.

Тэгээд тэр Кубад яах вэ, элчин сайд томилж байгааг дэмжиж байна. Гадаад харилцааны яамны бас туршилагатай хүн орж ирж байгааг сайшааж байна. Гэхдээ нөгөө Куба чинь жаахан алслагдсан газар шүү дээ. Тэгээд зах зээл нь ингээд очоод үзэхэд дөнгөж ингээж нээгдэж байгаа. Тэгээд тийшээ бас нөгөө Монголын хөрөнгө оруулалт орох боломж байгаа юм байна лээ шүү дээ. Бизнесийн орчин бас боломжтой юм байна лээ. Тэр тэр тал дээр бас бодож санасан юм байдаг юм уу, байдаггүй юм уу гэдэг. Нэг ийм ерөнхий асуудлууд байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 82 Батцэцэг сайд, Батмөнхийн Батцэцэг сайд хариулъя.

Б.Батцэцэг: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Доржханд гишүүний асуултад хариулъя. Их зөв асуудлыг хөндлөө. Өмнө нь бас 23 элчин сайд, дараа нь 3 элчин сайдыг томилоход бас ярьж байсан. Өмнө нь бид нар Элчин сайд нарыг явахад нь тусгайлсан гэрээ хийж байгаагүй. Одоо Элчин сайд нартай 5 заалттай ийм ерөнхий гэрээг байгуулаад, тэгээд жилд 2 удаа дүгнээд явж байгаа.

1 дүгээрт нь, энэ эдийн засгийн хамтын ажиллагааг яг сайжруулах вэ,

ямар төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх вэ? Энэ тал дээр илүү прагматик байх талаас нь.

2 дугаарт нь, энэ жуулчид татах, иргэдийн асуудал өөрийн манай орны иргэдтэй харилцах асуудалд илүү анхаарах ёстой. Жуулчид татах болон Засгийн газар хоорондын бодлогын баримт бичгүүдийг уялдуулах тал дээр дэвшил гаргах ёстой. Энэ дээр илүү прагматик байдлаар ажиллах ёстой гэсэн ийм даалгавруудыг өгч байгаа.

Энэ дээр Элчин сайд нар маань өөрснөө тус тусынхаа орныг нарийн судлаад, тухайн оронтой бид нар ямар түүхийн харилцаатай байсан юм, цаашидаа харилцаагаа илүү прагматик байдлаар буюу худалдаа, эдийн засгийн харилцааг нь илүү шинэ шатад гаргах ямар санал санаачилга байна гэдгээ өөрснөө дэвшүүлээд үүнийг ингээд сайдтай гэрээ байгуулаад явдаг болж байгаа. Энэ тодорхой хэмжээнд үр дүн гарч байгаа гэж үзэж байгаа. Эхний хагас жилийн дүгнэлтийг бид нар нэгтгээд, сайдын зөвлөлөөрөө бас хэлэлцсэн. Бүтэн жилийнхээр нь бид нар бас Их Хурлын гишүүдэд танилцуулах, Байнгын хороо дээр бас амлалт авч байсан. Танилцуулга Засгийн газар дээр би танилцуулахаар нэгтгээд бэлдчихсэн байгаа.

Тэгэхээр цаашидаа манай сайд нар яамны төлөвлөгөөнөөс гадна яг хувь хүнийхээ илүү оролцоог хангасан, илүү хүчин чармайлт гаргасан, илүү цаг үетэйгээ нийцсэн ийм прагматик байдлаар ажиллахаар, илүү ажилладаг болсон гэсэн үг.

Г.Занданшатар:

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууя. Ялгаварлан гадуурхсан асуулт асууж болохгүй. Манайх ардчилсан улс шүү.

Д.Өнөрболор: Би энэ Монгол-Солонгосын парламентын бүлгийн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

даргын хувиар, мөн Солонгосыг бас дагнан судалж, бас энэ нийгэм эдийн засгийнх нь харилцааг бас мэдээж ойлгодог хүний хувиар зарчмын хэд хэдэн бодлогын хэдэн асуудлуудыг ярьж. Мөн ганц нэг асуулт асууя гэж бодож гэж байна.

Ер нь Солонгос улс маш чухал улс. Монгол Улсын хувьд. Ер нь энэ геополитикийн талаас аваад үзсэн ч энэ эдийн засаг, хөрөнгө оруулалтын талаараа сая тэр Доржханд гишүүн ч гэсэн бас ярьж байна, аваад үзсэн Монгол Улсын хувьд маш чухал улс байгаа. Ер нь Солонгосын хувьд энэ дэлхийн нийгэм, эдийн засаг энэ геополитикт эзэлж байгаа байр суурь маш хурдтай өсөн нэмэгдэж байгаа. Үүнийг Батцэцэг сайд бас нэлээн сайн мэдэж байгаа байх. Сая л гээд тэгэхэд Жо Байдены Ерөнхийлөгчийн засаглал эхэлснээс хойш 2 улсад маш ач холбогдол өгч, урьж хамтын ажиллагаагаа бий болгосон, хамтын маш түүхэн ач холбогдол бүхий гэрээг байгуулсан. Нэг нь Францын Ерөнхийлөгч Эммануэл Макрон, нөгөөдөх нь БНСУ-ын Ерөнхийлөгч Юн Сог Ёль. Солонгос улсын хувьд ч гэсэн өөрсдөө потенциалын хувьд маш өндөр байгаа. Америк улсад 100 гаруй тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг хийхээр зарласан, 40 мянган ажлын байр нэмэгдүүлэхээр зарласан. Тэр байтугай Солонгосын иргэд, бөөрөндөө цөмийн бөмбөг тээгч онгоцыг хүртэл суурилуулж байгаа ийм бас геополитикийн бас гол тоглогч байгаа. Тэгэхээр бид бас цаашидаа энэ 30 жилийн хугацааны хамтын ажиллагаандаа дүгнэлт хийж Сандаг-Очир гишүүн, Даваасүрэн гишүүн ээ, дүгнэлт хийж ер нь цаашидаа болбол бид нар ганцхан дипломат улс төрийн ач холбогдол гэхээсээ илүү энэ хөрөнгө оруулалт, эдийн засгийн үр өгөөж тал дээрээ бас хамтарч ажиллах нь маш чухал байгаад байгаа юм.

Тэгээд энэ Солонгос улсад томилох элчин сайдын асуудал сүүлийн

жилүүдэд дандаа л нийгэмд чих дэлсээж байсан, ард иргэдийн бухимдлыг төрүүлж байсан. Нэлээн олон олон ийм асуудлууд ингээд өрнөсөн. Тэгээд ер нь энэ би бас сайдаас асууя. Энэ Гадаад харилцааны яам бас энэ сайд нарыг оруулж ирэхдээ Монгол Улсыг бас төлөөлж байгаа энэ сайдаар тавигдах шаардлага бас яг үндэслэл яг юу вэ гэж.

Нөгөөтээгүүр энэ нэр дэвшигчээс асуулт асууя. Ер нь ийм хэмжээний бас энэ потенциалтай улстай БНСУ-тай тийм ээ, энэ улсаа төлөөлөөд ажиллах нь ээ. Тэгэхээр энэ та 2 орны энэ хамтын ажиллагааг хөгжүүлэх, ялангуяа энэ эдийн засаг, хөрөнгө оруулалтын, хамтын ажиллагааг хөгжүүлэх тал дээр ер нь ямар арга хэмжээ авч ажиллах вэ? Үүнийг бас бодлогын хувьд бас тайлбарлаж хэлж өгөөч гэж бас хүсье.

Нөгөөтээгүүр манай энэ ард иргэдийн бараг нэг аймагтай тэнцэхүйц хэмжээний ард иргэд БНСУ-д амьдарч суурьшиж байгаа. Тэгэхээр тэдэнтэй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх чиглэлээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ? Одоо сая иргэдийн визний асуудал ч яригдана. Монгол иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээ авах асуудал ч яригдана. Хууль зүйн үйлчилгээ талаасаа ч тэр тийм ээ, энэ асуудлууд дээр та ямар байр суурьтай байгаа вэ? Ямар бодлого төлөвлөлттэй байгаа вэ гэдэг талаар бас асууя.

Г.Занданшатар: 82 Батмөнхийн Батцэцэг гадаад харилцааны сайд.

Б.Батцэцэг: Элчин сайдаар томилогдох улсуудад мэдээж тодорхой шалгуурууд тавьдаг. Энхбат нэр дэвшигчийн хувьд олон улсын харилцаагаар мэргэшсэн, сурсан, төрийн ажлын тодорхой туршилагатай, томилогдох гэж байгаа орондоо амьдарч байсан, ажиллаж байсан, сурсан. Солонгос хэлний өндөр мэдлэгтэй. Бусад бас шалгууруудыг хангаж байгаа учраас

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

тэнцэнэ гээд нэрийг нь дэвшүүлж байгаа.

Ер нь дипломат алба нь Элчин сайдаар буюу Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнээр салбарын бус хүмүүсийг буюу улс төрийн томилгоо хийх үзэгдэл зөвхөн манай оронд биш бас дэлхий нийтийн жишиг байдаг 20-30 хувьд нь бас бусад салбараас томилогддог ийм практиктай. Тэгэхээр Энхбат нэр дэвшигчийн хувьд удирдлагуудын түвшинд бас боломжтой гэж үзэж зөвшилцсөний үндсэн дээр дэвшүүлж байгаа.

Г.Занданшатар: 85 Батнямын Энхбат нэр дэвшигч.

Б.Энхбат: Эрхэм Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд та бүхний амар амгаланг айлтган мэндчилье. Тийм ээ, Өнөрболор гишүүний асуултад хариулъя. БНСУ бол Зүүн хойд Ази дахь Монгол Улсын гадаад бодлогод маш чухал байр суурьтай орнуудын нэг. Би 3 үндсэн том суурьтай ажиллана гэж бодож байгаа.

Ялангуяа таны хөрөнгө оруулалт, дэлхийн энэ өндөр технологитой үед яаж ажиллах вэ. 2021 оны 9 сард Монгол Улсын Ерөнхийлөгч, Солонгос Улсын Ерөнхийлөгч Стратегийн түншлэл гадаад харилцааны тунхгийг зарласан байгаа. 2 улсын худалдааны нийт барааны эргэлт 700-аад сая ам.доллар болсон. Нийт хөрөнгө оруулалт 595 сая доллар орчим байгаа. Үнэхээр БНСУ бол манай гадаад хөрөнгө оруулалтын гол улс, стратегийн түншлэлийн хүрээнд үзэл санаанд тулгуурлан 2 улсын харилцаа, хөрөнгө оруулалт, эдийн засаг, боловсрол, шинжлэх ухаан, байгаль орчин, эрүүл мэнд, соёл гээд олон салбарууд бий л дээ. Үүнээс үргэлжлүүлэн 2022 онд Улсын Их Хурлын дарга Занданшатарын айлчлалаар Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулах тухай Солонгосын талтай ярилцсан байгаа. Эдийн засгийн хэлэлцээ

нөгөө түншлэлийн хэлэлцээрийг буюу ЕРА /economic partnership agreement/-г байгуулснаар яг таны саяын хэлсэн худалдаа, хөрөнгө оруулалтуудын олон шинэ тогтвортой гарцууд нээгдэнэ гэж бас харж байна.

Үргэлжлүүлэн 2023 онд Монгол Улсын Ерөнхий сайдын хийсэн айлчлалаар бүр нарийвчлаад шинэ сэргэлтийн бодлого, Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2 улсын эдийн засгийн агуулгыг ялангуяа баяжуулах, түүн дотроо Орхоны хөндийн шинэ Хархорум хотыг сэргээн байгуулах, Хөшигтийн хөндий, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах, Солонгос улсын ноу хау дэвшилтэт технологит тааруулаад газрын ховор элемент, хагас дамжуулах түүхий эд нийлүүлэх гээд олон зүйлүүд ярьсан байгаа. Миний бие хэрвээ Элчин сайдаар томилогдсон тохиолдолд энэ 3 зүйл дээр суурилуулан аж үйлдвэр, дэд бүтэц, зам тээвэр, барилга, хот байгуулалт гээд олон чиглэлээр хичээнгүйлэн ажиллах болно.

Ялангуяа миний 20 гаран жил ажилласан ажлын туршилага, Солонгост байгаа улс төрийн хүрээлэл, том корпорацуудын захирлууд гэсэн энэ хүмүүс маань нэлээн суурь болж, дэмжлэг болж бас ажиллах боломжтой болов уу гэж бодож байна.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Би зүгээр санал хэлье.

Г.Занданшатар: Асуулт, үг 2 хамт байж болно.

Ц.Даваасүрэн: Би зүгээр санал хэлье. Тэгэхээр энэ Элчин сайд нарыг томилогдоход ер нь бас бид нар байнга л хэлдэг юм. Тэгээд 1 төдийлөн хэрэгжихгүй байгаа нэг асуудал байгаад байгаа юм. Та нар маань ингээд Их

Хуралд орж ирээд ярихаараа бол өө, ёстой очоод л ийм сайхан юмыг чинь хийгээд л өгнө. Өөрөө бол тэгээд л байна шүү дээ. Одоо барилгын салбарыг ч хөгжүүлнэ, тэрийг ч хөгжүүлнэ гээд л ингэдэг. Тэгээд яг очихоороо худлаа байдаг байхгүй юу. Элчингүүд юу хийдэг вэ гэхээр нэг айлчлал л яриад байдаг ерөөсөө. Гадаад харилцааны яам нь ч айлчлалаар дүгнээд байдаг, айлчлал л яриад байдаг. Тэрийг айлчлуулах гэсэн юм, үүнийг айлчлуулах. Гадаад харилцааны энэ ажил зөвхөн тэр биш шүү дээ. Зүгээр л одоо 3 өндөрлөгийг айлчлуулахын төлөө ажилладаг Гадаад харилцааны яам байж болохгүй. Тийм учраас хамгийн гол юм зүгээр тийм ээ, зүгээр арай тэгээд хэлчихэд хэтэрчих байх. Үндсэндээ бараг тагнуулын ажил хийгээд байгаа байхгүй юу, энэ гаднын байгууллагууд чинь. Тэр ноу хау технологиудыг чинь улс орондоо нэвтрүүлэх, тэгэхдээ өөр нэг ажил байна. Гаднын элчингүүдтэй ярьж байна. Гаднынхантай ярьж байхад. Үгүй ээ, ерөөсөө тэр хувийн хэвилийнхнийгээ, иргэдээ үнэхээр хамгаалах юм. Манай хувийн компаниудыг та нар ингэсэн байна гээд л ингээд л орж ирээд л манай тэр компанийн асуудлыг ингэсэн байна гээд л. Манай элчингүүд тийм юм байхгүй шүү дээ. Үнэхээр байхгүй. Хөөрхий нэг Монгол тэнд ядарчихсан явж байхад манай Элчин сайдын яам түүний төлөө ороод гүйгээд, тэр бусад яамдаар нь гэдэг юм уу ороод Гадаад харилцааны яам дээр нь очоод манай тэр бизнесмений эрх ашиг хохирсон байна гэж ярьж байгаа элчин байхгүй. Гэтэл энд байгаа бүх элчин өөрсдийнхөө, тэр компанийн, тэр иргэний эрх ашгийн төлөө бидэнд байнга ярьж байна шүү дээ. Манай компанийг тэгчихсэн байна, та нар, манай компанийн эрх ашгийг ингэж хохироочихсон байна гээд ингээд манай иргэнийг ингээд явж байна гээд ярьж байна шүү дээ. Тэгэхэд манай Гадаад харилцааны яам үндсэн ийм ажлаа хийхгүй байна. Энэ ажлыг ерөөсөө хийхгүй байна. Тэнд иргэдийн эрх ашиг яаж байгааг, муу ядарсан Монгол

тэнд очиж нэг амьдрах гэж яваа шүү дээ. Тэгэхэд түүнийхээ төлөө зогсох ганц хүн нь одоо энэ манай Элчингүүд шүү дээ. Тэгэхэд түүнийг тоохгүй нэг том айлчлал яриад байна, 3 өндөрлөгийг л нэг айлчлуулахын төлөө л Элчин сайдын яам байдаг гэж ойлговол дэндүү буруу ойлголт байхгүй юу.

Тийм учраас 1 дүгээрт, та нар тэр компаниуд, хувь хүнийхээ эрх ашгийн төлөө ажилла.

2 дугаарт, энэ улс оронд хэрэгцээтэй тийм юм байвал тэрийг Монголдоо авчрахын төлөө ажилла. Маш их боломжууд байгаа шүү дээ. Жишээлбэл, би Канадад гээд тэгэхэд энэ яг хүйтэн улиралтай тэр бүс нутагт байгаа тэр барилгын технологиудыг, тэр эрчим хүчний технологиудыг, тэр шинэ гарч байгаа тэр хүйтэн нөхцөлийн технологиудыг Монголд оруулж ир л дээ. Модны салбар маш өгөөжтэй хөгжсөн орон. Тийм учраас гадаад оронд байгаа манайд нэвтрүүлэх боломжтой боломжийг Монголд жуулчлахад та нар ажилла аа.

Дахин хэлье. 3 хүний айлчлалын төлөө ажилладаг гадаад харилцааны салбар гэж байж болохгүй. Тэрэндээ манайд өнөөдөр хөгжиж чадахгүй байгаад байна шүү дээ, манай орон. Тийм учраас 2 зүйлийг захилаа шүү.

Иргэд, компанийнхаа эрх ашгийн төлөө зогсдог Гадаад харилцааны яам бай.

2 дугаарт, гадаад оронд байгаа боломжийг Монголд бий болго. Хамтарч ажилла. Ийм л зүйлийг би та нарт хэлье. Үүнийг хийхгүй байгаа шүү. Үе үеийн Гадаад харилцааны яам үүнийг хийхгүй байгаа. Элчин томилогдох бүрд бид нар үүнийг хэлж байгаа. Элчингүүд ... /минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэлсэн. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Миний бас ярих гэж байсан зүйл Даваасүрэн гишүүнийхтэй төстэй байна л даа. Энэ нөгөө нэг ковид цар тахлын дараа геополитикийн нөхцөл байдал, улс хоорондын биетэйгээ харьцаж байгаа ялангуяа гадаад худалдаа энэ тэрд нэлээд өөрчлөлтүүд орж байна. Бид нар бас сая Монгол-Германы парламентын бүлэг, ХБНГУ-д Бундестагийн урилгаар айлчлаад л ирлээ. Бас ингээд харж байхад томоохон гүрнүүдийн энэ ер нь худалдаа, түншилэл, улс төр, эдийн засгийн харилцаанд ихээхэн өөрчлөлт орж байгаа. Тэгээд бас ер нь хэт их хамааралтай байх энэ тэр асуудлууд эргээд улс орны үндэсний аюулгүй байдлын асуудал хүртэл ингээд л хөндөгдөөд явж байна.

Тэгэхээр би бас Батцэцэг сайдаас голлож асууя гэж бодож байгаа юм. Бид нар өмнө Элчин сайд нарыг орж ирэх болгонд гадаад дахь Элчин сайд нар улс орондоо хэдий хэмжээний хөрөнгө оруулалт оруулж ирэв, эдийн засгийг хөгжүүлэхэд иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд ямар хувь нэмэр оруулав гэдгээр нь ажлыг нь дүгнэж байя гээд бүр энд тохироод л, энд чинь бүгд яриад л ингээд хэдэн жил болж байгаа. Мэдээж яг энэ чиглэлээр тодорхой үр дүнд хүрээд томоохон хэмжээний хөрөнгө оруулалт оруулж ирсэн нэг, хоёрхон Элчин сайдыг л нэрлэж болох юм байна. Бусад нь яг саяын хэлээд байгаа шиг үнэндээ айлчлалд хөл дарагдаад эсвэл нэг хэдэн дарга нар ирэхэд нэг үйлчилдэг ч юм уу ингээд л нэг гүйгээд цаг хугацаа маш их алддаг л даа. Тэгэхээр ялангуяа энэ улс оронд энэ геополитикийн нөхцөл байдлаас харахад гадаад худалдаагаа эдийн засагжуулах, энэ хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, Монголоо зөв сурталчлах асуудал дээр Гадаад харилцааны яам бүр цогц нарийн арга хэмжээ авч явуулах хэрэгтэй байна. Одоо энэ явж байгаа би сая Солонгос улсаас гэхэд өдөрт 70-80 онгоц ирж байгаа гэсэн хэр нь яг Солонгосоос жуулчид ирж байна уу.

Үнэхээр Монголд нээрээ тэр нэмүү өртөг шингэсэн бизнесийнхэн орж ирж байна уу, хөрөнгө оруулалтыг татах хүмүүс нь ирж байна уу, үгүй юу гээд бас тэнд байгаа төлөөлөгчтэй нь уулзаад үзэхэд тэр талаасаа цөөхөн. Монгол талаасаа харин Монголчууд маань өөрсдөө нэг их жуулчлал маягаар ч гэдэг юм уу, халти очоод буцаж ирэх Монгол талаасаа их байна. Солонгос талаасаа цөөхөн байна гээд ярьж байгаа байхгүй юу. Тэгээд энэ гэтэл бид нар өнөөдөр энэ “аялал жуулчлалын жил” болгосон бараг л энэ 3 жилийг дараалаад “аялал жуулчлалын жил” гэж Засгийн газар зарлаад л байдаг. Гэтэл яг үнэндээ тэр Солонгосоос, Японоос ирж байгаа жуулчдын тоо ч бага байна, тэнд сурталчилгаа ч тааруухан байна. Энэ дээр жишээ нь Солонгос улс байна. Япон улс дээр байна.

Сая гэхэд энэ Японы маркетингийн аялал жуулчлалын газруудтай ярьж байгаад нөгөө өндөр өртөгтэй тэгээд Монголд үнэхээр зочид буудал тэр өндөр мөнгө төлөөд орж ирдэг нэлээд олон тооны жуулчид орж ирэх гэж байтал суудал зочид буудал энд асуудлууд ийм бай тийм байна гэж бие бие рүүгээ нөгөө Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гадаад хэргийн яам ингэсээр байгаад тэд нар нь цуцлаад өөр улс руу явахаар болсон гээд л ярьж байгаа байхгүй юу. Тэгээд иймэрхүү зүйл дээр нөгөө Гадаад хэргийн яам, Элчин сайдын яам, тэр холбогдох яамдтай шуурхай ажиллаад иймэрхүү зүйлийг бид алдмааргүй байна л даа. Одоо дандаа яриад байгаа аялал жуулчлалыг хөгжүүлнэ, аялал жуулчлалаас бид бараг уул уурхайгаас дутуугүй ашиг олно гээд л энд ингээд том том яриад байдаг. Үнэн хэрэгтээ үйлдэл дээрээ ажил, хэрэгжилтүүд муу, яамд хоорондын уялдаа холбоо их тааруу байна л даа. Тэгээд энэ зүйл дээр Батцэцэг сайд аа, та яг яг энэ гадаад харилцааг эдийн засагжуулах, Элчин сайд нараа, Элчин сайдын яамдаа энэ хөрөнгө оруулалтыг татах энэ дээр ямар яг цогц бодитой

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаараа нэг товч мэдээлэл нэгд өгөөч гэж хүсэх байна.

2-т нь, энэ Төрийн хэмнэлтийн хууль гадаад дахь Элчин сайдын яамдыг яг дорвитой томоохон бүтцээрээ үйл ажиллагаа явуулахад үнэхээр ингээд хөл тушаа болж байна гэсэн мэдээллийг бас Элчин сайдын яамнуудаас яриад байгаа. Тэгэхээр үнэхээр бас ийм зүйл байна уу? Хэрвээ тийм бол жишээ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулаач гэдэг юм уу. Энэ Монголоо сурталчлах, гаднаас хөрөнгө оруулалт татах, Элчин сайдын яамнууд яг энэ бололцоогоороо сайн ажиллах, үүнийг нь олгох зэрэг энэ тэр асуудал дээр үнэхээр тийм зүйл байвал та нар бас шуурхай арга хэмжээ авах нь зөв болов уу гэсэн бодолтой байна. Тэгээд энэ дээрээ хариулт авъя гэж бодож байна.

Г.Занданшатар: Хэн хариулах уу? 82 Батцэцэг сайд, Батмөнхийн Батцэцэг сайд хариулна.

Б.Батцэцэг: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Би түрүүн, та бас эзгүй байсан байх. Доржханд гишүүний асуулттай давхцаж байна. Бид нар ноднингоос эхлээд 23 Элчин сайдыг томилоход бас гишүүдийн саналын дагуу бүх Элчин сайд нартай тусгайлсан гэрээ байгуулж явж байгаа. Хөрөнгө оруулалтыг яаж татах вэ? Ямар төсөл бүр тухайн оронтой хэрэгжүүлэх вэ? Эдийн засгийн хамтын ажиллагааг прагматик байдлаар яаж өөрчлөх вэ, ямар ахиц дэвши авчрах вэ? Жуулчид яаж татах вэ? Иргэдийн асуудлыг бүр онцгойлон ярьдаг. Иргэдтэй холбоотой асуудлууд маш их шийдэгдэж байгаа. Тэгээд 2 орны энэ Засгийн газар хоорондын бодлогыг урт, богино хугацааны бодлогыг уялдуулах чиглэлээр ийм 5 заалттай гэрээнүүдийг тусгайлан байгуулаад, дүгнэлтийг нь ингээд дүгнээд бид нар хагас жилээр, бүтэн жилээр гаргасан. Энэ Элчин сайд нарын тус

бүрийнх нь тайлангийн нэгтгэлийг гишүүн танд явуулъя. Доржханд гишүүнд бас явуулъя, Даваасүрэн гишүүнд явуулъя.

Айлчлалыг үр дүнгүй зүгээр айлчлал хийгээд ингээд хөөцөлдөөд гүйгээд байдаг гэж буруу ташаа ярьж болохгүй байх гэж бодож байна. Яагаад гэвэл энэ өндөр хэмжээний энэ айлчлал хийх тусмаа манай улсад ашигтай хэрэгтэй байдаг. Энэ айлчлалуудаар өндөр түвшинд маш олон эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлуудыг бусад энэ хоорондын харилцааны олон жил гацсан асуудлуудыг гацаанаас гаргадаг, ярьж тохирдог, олон жил хүлээсэн баримт бичгүүдийг байгуулдаг. Энэ бол харилцаанд үнэлж баршгүй ийм хувь нэмрийг оруулдаг. Тийм учраас энэ айлчлалууд идэвхжиж байгаа нь өөрөө харилцаа идэвхжиж байгаа, 1 дүгээрт.

2 дугаарт, харилцаа болон энэ хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагаа бэхжиж шат ахиж байгаа гэж хэлэхийг хүсэж байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн асуудал яах вэ, мэдээж сүүлийн жилүүдэд манайх энэ жишээлбэл ёслолын зардал, янз бүрийн арга хэмжээ зохион байгуулах, олон улсын арга хэмжээ, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах зардлууд, хөрөнгө оруулалтын зардлууд танагдаж байгаа хэдий ч байгаа бололцоогоороо үйл ажиллагаануудаа хэвийн явуулж байгаа. Гэхдээ мэдээж ер нь бусад дэлхийн дипломатуудтай харьцуулах юм бол Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн газруудын зардал маш төсөв нь бага байдаг. Цалин нь дунджаас 40 хувиар бага байдаг. Томоохон хэмжээний улс орноо сурталчилсан арга хэмжээ зохион байгуулах, Монголчуудынхаа дунд тэмцээн, уралдаан тэднийг бас нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан төлөвлөсөн арга хэмжээнүүдийг нь зохион байгуулах зардал дутмаг байдаг. Тэгээд цаашдаа нэмүүлэе гэдэг саналыг

манайх байнга тавьдаг. Тэгэхдээ тодорхой хэмжээнд шийдээж байгаа.

Гадаад сурталчилгаа хийх зардал хэзээ ч төсөвлөгдөж байгаагүй. Өнгөрсөн жилээс эхлээд тодорхой төсөв ингээд тавигдаад Соёлын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтраад тодорхой ажлуудыг зохион байгуулж байгаа. Өмнө нь энэ өндөр дээд хэмжээний айлчлалын үеүдээр бас бид нар бизнес форум зохион байгуулах, соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах, айлын талтай нийлээд ийм бас гадаад сурталчилгааны ажлуудыг зохион байгуулж хэвшиж байгаа.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Батцэцэг сайд аа, танд чуулганы танхимд гишүүн асуулт асууж байна. Доржханд гишүүн асууж байхад би суудал дээрээ сууж байсан. Бас зөв мэдээлэл 1-д өг.

2-т, та шууд хариулах гэж би хүсэж байна. Та сая хэлж байна. Элчин сайдуудыг бид дүгнэж байгаа, дүгнэлтээ гаргасан гэлээ. Тэгвэл эхний 3-д ямар яамны аль Элчин сайдын яам яг та нарын хэлсэн гадаад харилцааг эдийн засагжуулах, улс оронд хөрөнгө оруулалт татах, таны хийсэн дүгнэлтийг сайн хийсэн гээд тэр дүгнэлтээ надаа яг одоо хэлээдэх. Би чуулганы танхимд танаас асуулт асууж байна.

2-т нь, айлчлал буруу гэж нэг ч гишүүн яриагүй. Айлчлал маш чухал. Тэр тусмаа төрийн 3 өндөрлөгийн айлчлал ямар байдгийг би, бас дандаа цуг явж сурвалжилга хийж тэрийгээ Монгол түмэндээ болон гадаадад сурталчилж явсан хүний хувьд маш сайн мэднэ. Харин айлчлалын хүрээнд хийх ажил, хэрэгжүүлэх ажил чухал байдаг юм. Энэ дээр Гадаад хэргийн яам муу ажиллаж байна. Тийм учраас Гадаад хэргийн яамнаас Гадаадын хөрөнгө оруулалтын газрыг Эдийн засгийн хөгжлийн яаман дээр бараг салгаж ирж байж, энэ

хөрөнгө оруулалтыг эзэнтэй болгох асуудлыг чуулган дээр хүртэл Засгийн газар, Улсын Их Хурал ярина шүү ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоогүй юм байна. Элчин сайд нарын асуудал хэлэлцэж байгаа. 82. Дүгнэлттэй холбоотой асуудал хариулъя. 82 Батмөнхийн Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: 32 элчин сайдын тайланг танд явуулъя. Эхний 3 байранд АНУ, Францад ажиллаж байгаа Элчин сайд, Япон, Солонгос гэсэн 4 орныг нэрлэж байна. Би үр дүнгүүдийг нь 5 заалтаар дүгнэлтүүдийг нь гаргачихсан байгаа. Тэр материалыг танд хүргүүлъя.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Элчин сайдууд олон хүн байгаа болохоор Гадаад харилцааны сайдаас л дунд нь асуучихъя. Ер нь гадаад улс оронд байгаа манай Монгол иргэдийн ямар эрх ашиг голчлон зөрчигддөг юм, ер нь. Тэр тусмаа эдгээр орнуудад болоод ер нь нийт гадаад улс оронд байгаа Монгол иргэдийн ямар эрх ашиг давамгайл зөрчигддөг юм. Үүн дээр манайхан цаашид анхаарч засаж, залж ажиллах чиглэл дээр ямар ажлууд хийгдэж байгаа юм. Гол нь иргэдийн эрх ашиг. Бас тэгээд энэ иргэдийн эрх ашигийн чинь цаана эдийн засгийн эрх ашиг, бизнесийн эрх ашиг гээд олон зүйлүүд бас энд хамаарах байх. Өргөн утгатай ойлгох байх.

2 дугаарт нь, энэ гадаад худалдаа, энэ тарифын ялгаа, чөлөөт худалдааны хэлэлцээр гэдэг асуудлууд нэлээн тийм бодитой ажлууд. Эдгээр томилогдож явж байгаа 4 улс орон дээр энэ яг одоогийн байдал ямар байгаа юм? Цаашидаа ер нь энэ Элчин сайдууд ямар үүрэг даалгавартай явж байгаа юм? Жишээ нь Японтой чөлөөт худалдааны хэлэлцээртэй. Түүн дээр бас сайн муу, ашигтай ашиггүйгийн яриа гардаг.

Солонгос улстай эдийн засгийн нэлээн өргөн харилцаатай. Канад улстай бас нэлээн тийм газар зүй, цаг уур, олон талаараа манайх бас их ойролцоо ийм улс орон. Тэгэхээр эдгээр Элчин сайдууд ер нь яг ямар тодорхой үүрэг даалгавруудтай ахиц дэвшил гаргахаар явж байгаа вэ? Саяын тэр таны хэлдэг Элчин сайдуудын ажил үүрэг, эдийн засгийн оролцоон дээр Япон, Солонгос хоёрын Элчин сайд сайн ажилласан гэж байна. Тэгээд үүн дээр ямар ахиц дэвшил гаргах үүрэг даалгавруудтай явж байгаа вэ? Эдгээр дээр мэдээлэл өгөөч.

Г.Занданшатар: 82, Гадаад харилцааны сайд Батмөнхийн Батцэцэг.

Б.Батцэцэг: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Хилийн чанадад нийтдээ дэлхийн 90 гаруй оронд Монгол Улсын 197 мянга орчим иргэн оршин сууж байгаа. Хууль ёсоор оршин сууж байгаа 139 мянган иргэн 0-16 насны 20 мянга, оюутан 28 байгаа. Тулгамддаг асуудлын хувьд мэдээж оршин суух зөвшөөрөл буюу визний асуудал байдаг.

2 дугаарт нь, эрүүл мэндийн асуудал.

3 дугаарт нь, эрх ашиг нь хохирсон, төлбөрийн чадваргүй болсон иргэд янз бүрийн хүнд байдалд орох ийм асуудлууд байдаг. Үүнийг шийдэхийн тулд бид нар 1 дүгээрт яах вэ, Элчин сайдын яамнууд дээр хуучин Консулын газрууд байхгүй газрууд дээр бид нар 5 орон дээр өнгөрсөн жил гэхэд Консулын хэлтэс байгуулсан. Зөвхөн иргэдийн асуудлыг хариуцсан дипломатуудыг томилсон байгаа гэсэн үг. Хамгийн их асуудал гардаг газар бол мэдээж БНСУ. БНСУ дээр Консулын хэлтэс дээр бид нар орон тоог нь нэмээд, иргэдэд туслах сангийн төсвийг бас хуучин 180 орчим сая төгрөг байдаг байсан бол энэ жил 392 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн. Энэ бас иргэдийн тусалцаа дэмжлэг үзүүлэх ийм боломжийг бий болгож байгаа. Иргэдтэйгээ шууд харьцаж

байгаа. Гадаад харилцааны яамны веб сайт, пэйж хуудас, *consul.mn*, шууд дуудлагын утсуудаар гомдол, хүсэлт, Солонгост байгаа Элчин сайдын яам дээр Консулын хэлтэс дээр байнгын ингээд 24 цагийн ажиллагаатай, бас айлын талын бас хууль хяналтын байгууллага, төрийн бус байгууллагуудтай бас хамтарч ажиллаж аль болохоор иргэдээ хохироохгүй, эрх ашиг нь хохирсон улсуудад тусламж дэмжлэг өгөх талаар Элчин сайд нартаа тусгайлан үүрэг даалгавар өгч, сүүлийн жилүүдэд сайжирч байгаа. Гэхдээ бүрэн асуудлуудыг нь шийдэж чадахгүй байгаа.

2 дахь асуудал нь, оршин суух зөвшөөрөлтэй холбоотой визний асуудал. Солонгос улсад маш олон иргэн, 17 мянган иргэн хууль бусаар оршин сууж байгаа. Энэ Солонгост зорчиж байгаа Монгол иргэдийг шатлалтайгаар визний нөхцөлийг нь хөнгөлөх, цаашидаа визгүй болох асуудлыг бас Ерөнхий сайдын айлчлалаар тавьсан. Солонгос улсын Монгол Улсын энэ Хууль зүй, дотоод хэргийн яамд болон Гадаадын иргэн харьяатын газар ажлын түвшиндээ ажиллаад, судалгаагаа хийгээд, харилцан айлчлаад энэ ажил бас нэлээн урагштай явж байгаа.

Тийм, тэгээд манай Элчин сайдаар нэр дэвшиж байгаа хүмүүс бас тус тусынхаа оронд энэ эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын харилцааг сайжруулах тал дээр өөрснөө бас төлөвлөгөө гаргаад, түүнийгээ бас танилцуулах боломжтой гэж бодож байгаа. Зүгээр ерөнхий тавигдаж байгаа бүх Элчин сайд нарт тавигдаж байгаа шаардлага бол мэдээж энэ эдийн засгийн, худалдааны хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах, хөрөнгө оруулалтыг татах, иргэдийн асуудал, энэ бодлого шийдвэртэй холбоотой, жишээлбэл, жуулчид татах, Монгол Улсын гадаад сурталчилгааг хийх гэсэн ийм даалгавруудыг гэрээгээр ажлынх нь төлөвлөгөөгөөр нь үүрэг даалгавар өгөөд ажиллаж байгаа.

Тайлангуудыг нь бид нар хагас жил тутам дүгнэж байгаа. Өдөр тутмын удирдлагаар чиглэлийн газрууд Засгийн газраас гарсан шийдвэрүүдийг биелүүлэх чиглэлээр ажиллаж байгаа.

Г.Занданшатар: Дэгийн зөрчил гэдгээр үзнэ. Хариулт дуусан. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Надад асуулт байхгүй санал байгаа. Тэгэхдээ энэ бага хугацаанд энэ саналуудыг ярьж чадахгүй учраас би Батцэцэг сайдад ингээд бичгээр энэ саналыг бэлдсэн байгаа, 3 хуудас. Бид нар зөвхөн нэг эдийн засагжуулах ёстой л гээд байхаас биш яг ямар гарц шийдэл байгаа юм бэ гэдгийг нь би бас өөрийнхөө энэ тооцоо судалгаа дээр үндэслээд ингээд гаргасан байгаа.

Ер нь энэ ингээд тоо харахаар манай улс бас хангалттай олон оронд ингээд Элчин сайдын яам, консултай байгаа харагдаж байгаа юм л даа. Гэхдээ яг энэ гадаад харилцаагаа эдийн засагжуулахад бид нар энэ жоохон энэ хүний нөөцийн бодлого нь их буруу, дутуу явж байна. Тэгэхээр энэ дээр их онцгой анхаарах ёстой. Би энэ талаар бас Содбаатар даргад бичгээр энэ саналуудаа хүргүүлсэн байгаа. Тэгэхээр ер нь энэ шийдэл нь ямар юм бэ гэхээр одоо энэ Элчин сайдын яамнууд дээр худалдаа эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх мэргэжилтэн нь ерөөсөө 1-2 хүн л байгаа. Тэгэхээр ялангуяа энэ манай хөрш Хятад орон чинь эдийн засгийн нэлээд хурдацтай хөгжиж байна. Энд бид нар тэр нэг хуучин орон тоогоор явахгүй л дээ. Нэг 3, 4 хүн, дээд тал нь 5 хүн хариуцаж байгаа. Энд бүр тусгай энэ технологи, мэдээлэл, энэ дипломат ажилчдын энэ эдийн засагчдын ийм нэлээн том орон тоог нэммээр санагдаж байгаа юм. Ингэж байж бид нар энэ цаг хугацааг ашиглахгүй бол үнэхээр хүмүүс нь хүрэлцдэггүй юм байна лээ. Ялангуяа Японд ч гэсэн тэр, БНСУ-д ч гэсэн тэр бас энэ орон тоог зоригтой нэмэх

байхгүй юу. Тэгж байж ажиллахгүй бол тэр нэг хүн чинь юугаа ч мэдэхгүй.

Дээрээс нь энэ би энэ өмнө нь манай улс энэ гадаадын зээл тусламж их амжилттай хэрэгжиж байх үеийн юуг ингээд судлаад үзэхээр эдийн засгийн зөвлөхийн аппарат маш сайн ажилладаг байсан байгаа юм. Тэгэхээр энэ Элчин сайд бүх юманд ингээд гүйгээд байж чадахгүй. Тэгэхээр эдийн засгийн зөвлөх бол маш өндөр харилцааны тийм авьяастай, соёлтой, хэлтэй ийм хүн тэр тухайн орны нөлөө бүхий албан тушаалтнуудтай уулздаг, санал солилцдог, хөрөнгө оруулалтаа зоригтой татдаг, төсөл хөтөлбөрүүдээ танилцуулдаг ийм мундаг хүмүүс байх ёстой, эдийн засгийн зөвлөхүүд. Тэгэхээр энэ дээр онцгой анхаарч бас ажиллах хэрэгтэй байна.

Дээрээс нь энэ зүгээр нэг Монголчуудын нэг асуудал шиг консулын үйлчилгээ биш энэ худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлдэг ийм цэг болгомоор байгаа юм. Ялангуяа манай хувийн хэвшлийнхэн их ирж очдог, экспо гээд л. Энэ дээр нэлээд ажил сайн анхаарч ир дээ.

Дээрээс нь энэ зөвлөн хүчний бодлого. Одоо энэ 26 улсад 129 Монголчуудын холбоо гэж байгаа. Тэгэхээр энэ холбоог бас үйл ажиллагааг нь зангидаад, дэмжээд энэ холбоодтой нийлээд сайн ажиллаасай гэж би энэ шинэ Элчин сайдуудыг л хүсэж байна. Тэгээд ер нь энэ гадаад харилцаагаа эдийн засагжуулаад энэ эрчтэй шинэ бодлого хийхэд бид нар цаг маш бага байгаа. Тэгэхээр энэ эдийн засгийн харилцаагаа онцгой хөгжүүлбэ гэсэн газарт би орон тоогоо, хүнээ зоригтой хийгээч ээ л гэдгийг хэлэх гээд байгаа юм. Үүнийгээ би Хүрэлбаатар сайдад бас албан ёсоор тавьсан. Ерөнхий сайдад бас тавьсан. Тэгэхээр үүнийг нэг шинэ шатанд гаргамаар байна. Зүгээр л нэг хуучин сэтгэхүйгээрээ явмааргүй байна шүү дээ. Бид нар чинь энэ дэлхийн

геополитикийн асуудал өөр болчихлоо. Монголтой харилцах улс орнууд хүртэл нэлээд бий болчихлоо. Тэгэхээр энэ дээр битгий цаг алдаач ээ гэдэг ийм л зөвлөмж өгөх гэсэн юм. Тэгээд би саналаа бичгээр хүргүүлье.

Г.Занданшатар: Одонтуяа гишүүн санал хэллээ. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн. Алга байна, хаслаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Бүгдээрээ сайн байцаана уу? Тэгэхээр өнөөдөр энэ гадаад элчин сайд нарын томилгоо явагдаж байна. Тэгэхээр энэ ковидын үеэр маш их тийм зөрчлүүд, хүний эрхийн зөрчлүүд маш их гарсан. Тэр хүний эрхийн зөрчил дээр албан тушаалтны асуудлууд бас их гараад байсан ийм талууд байгаа. Ялангуяа манай орны маш их олон иргэд ажиллаж, амьдардаг БНСУ-д олон мянган хүн тэнд ажиллаж амьдарч байгаа. Дээрээс нь нааш нааш цааш гол дамжин өнгөрдөг ийм нутаг. Тэгээд энэ дээр ковидын үед маш цөөхөн хүн нааш цааш зорчих үед ялангуяа хүн хүмүүсийн эрх маш их зөрчигдсэн. Тэр эрх зөрчих дээр ялангуяа тийгээ авчихсан тэр хүмүүсийг билетийг нь хойшлуулах, янзлах асуудлыг энэ Солонгос улсад нэр дэвшиж байгаа дэвшиж байгаа хэн билээ, Энхбат. Тэгээд энэ дээр нэлээн асуудлууд гарсан, гомдлууд над руу ингээд намайг л нэг юм хэлчих байх гэж иргэд их ханддаг юм шүү дээ. Бусад нь хэлж чадахгүй байх. Одоо ингээд би ч бас яах вэ, нэлээн хэдэн түрүүчийн 20 хэдэн дипломат орж ирэхэд би 2, 3 Элчин сайдыг шүүмжилсэн юм. Дараа нь очиход бас жсоохон нүүр халуун л байдаг юм байна лээ, хэцүү юм байна лээ.

Тэгэхдээ иргэдийн үгийг хэлэхээс өөр арга байхгүй. Иргэд над руу хандаж, үг хэлж байна. Өөрөөр хэлбэл ковидын үеэр маш цөөхөн нислэгтэй байж байхад, маш цөөхөн суудалтай байж байхад тэр суудлыг нь авчихсан хүмүүсийн билетийг нь зохицуулсан, нааш цааш болгосон, түүнээсээ хохирсон гэдэг хүмүүсийн

гомдол Энхбат нэр дэвшигч тань дээр маш их гараад байна. Тэгээд ийм, ийм асуудлууд байсан юм уу, байгаагүй юм уу. Тэгээд янз янзын тэр нислэгтэй холбоотой л асуудлууд их байсан юм байна. Тэгээд тэнд чинь зовсон, зүдэрсэн, ядарсан, тэр бүх хүмүүс тань дээр хүрээд ирнэ. Тэгээд нөгөө нэг танил талдаа ханддаг шиг хандаад, тэр хүмүүсийг гомдоогоод ингээд яваад байх юм бол наадах Монгол төрийн нэр хүнд бас тэнд унах ийм нөхцөл байдал руу орно шүү дээ. Ядарсан улсууд л тэр Элчин сайд дээр очиж, консул дээрээ очиж, гомдлоо гаргаад нэг үгээ хэлж аваад л буцна л даа. Тэгээд бүгдийг нь шийднэ гэж бас байхгүй л дээ, мэдээж.

Тэгээд энэ тохиолдолд хуучин байснаараа ингээд байгаад байх юм уу? Энэ дээрээ ямар байх юм одоо мэдэхгүй. Мэдээж Монгол Ардын нам оруулж ирж байгаа юм чинь ихэнх нь бүгдээрээ дэмжээд явчих байлгүй. Тэгэхдээ би ямар ч байсан тэр гомдоод байгаа тэр хүмүүсийн гомдлыг бас хэлэх нь зүйтэй л гэж үзэж байна. Тэгээд энэ дээр хариулт авъя.

Г.Занданшатар: 85, Батнямын Энхбат нэр дэвшигч.

Б.Энхбат: Эрхэм гишүүний асуултад хариулъя. Тийм ээ, дэлхий даяар ковид хэмээх гэнэт тооцоолоогүй өвчин гарч ирж, их олон хүнийг зовоосон. Тэр дотроо гадаадад Солонгос улсад маш олон хүн гэнэт нэг өглөө гацсан. Би яг газар дээр нь эхлэхээс нь авхуулаад ковид дуусах 5 сарын, ноднин жилийн 5 сар хүртэл ковидтой тэмцэлдэж ажилласан. Маш олон хүмүүс санал, гомдол тавьдаг байсан. Тэр үеийн нислэгийг тусгай үүргийн нислэг гэж нэрлэдэг байсан. Тусгай үүргийн нислэгт нийтдээ гэнэт гацсан 30 гаран мянган хүнээс 250 хүн л сууж явдаг байсан. Энэ бүх шийдвэрийг Улсын онцгой комисс штаб дээрээс гаргадаг. Бид нар штабаас ирсэн нэрсийн дагуу тийгийг нь бичээд иргэдийг эх орон

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

руу нь буцааж явуулдаг байсан. Таны асуултад хариулж дууслаа.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Одоохон бас нэг гомдол бичсэн цаасаа мартчихлаа. Хайгаад олдоггүй ээ, болилоо.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн алга байна, хаслаа. Одоо 3 гишүүн 2, 2 минут асуулт асууж, үг хэлсний дараа санал хураалт явуулах тул гишүүд чуулганы танхимд цугларна уу. Гишүүдийг чуулганы танхимд дуудъя, санал хураалт явуулна.

Нямаагийн Энхболд гишүүн 2 минут, Ням-Осорын Учрал гишүүн 2 минут, Гонгорын Дамдинням гишүүн 2 минутад багтааж байгаа, асуулт асууж, үг хэлнэ.

Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Баярлалаа, дарга аа, багтаана аа, 2 минутдаа. Засгийн газраас санал болгоод Монгол Улсын Ерөнхийлөгч дэмжээд оруулаад ирсэн Элчин сайд нарын асуудлыг дэмжиж байна, би хувьдаа. Гадаад яамны хийдэг ажил, хийж байгаа ажил, хийх ёстой ажлын талаар хүмүүс нэлээд ярилаа. Энэ дээр санал нэг байгаа. Тэгэхдээ 1 ийм юмыг анхаармаар байна. Энэ сая нөгөө Элчин сайд нарын ажлын тайлан гаргаад, үнэлээд ирүүлж байна гэлээ шүү дээ, тийм ээ. Түүнийгээ үнэлээд өгсөн даалгавар чинь хэдэн хувьтай биелсэн байна гэдгээ гаргаад тэгээд хэрэв болж өгвөл анализ дүгнэлт хийгээд яг юу хийж вэ, хангалттай юм хийж үү үгүй юү. Хангалттай хийсэн бол хангалттай, хангалтгүй хийсэн бол хангалтгүйгээр, хангалттай хийсэн гэж үзвэл тэгвэл үр дүн нь ямар байна? Үр дүнг нь хангалтгүй гэж үзэж байгаа бол хэдэн хувь нь Элчин сайдын ажлаас шалтгаалав, хэдэн хувь нь тэр цаад

орных нь байр сууриас шалтгаалав гэдгийг нь ялгаж салгаж өгч байвал та нарын ажилд ч, Улсын Их Хурлын ажилд ч хэрэгтэй юм байгаа юм. Яг хэрэг дээрээ бид нар чинь өөрснөө жижиг улс, элчин сайд яаж ч ажиллалаа гэсэн саад улсын сонирхол гэж бас юм байна. Манай дотоод нөхцөл байдлыг харна, манай хууль тогтоомжийг харна, улс төрийн тогтвортой байдлыг харна. Хэлснээсээ буцаж байна уу үгүй юү гэдгийг харна. Тэгээд Монголд тэд нарт хэр зэрэг сонирхолтой юм гэдгийг нь бас харна шүү дээ. Үүнийг та нар бүгдийг нь хэрэв ялгаж, салгаж, дүгнээд оруулж ирж, чадаж байвал Их Хурал дээр ярихад ч гэсэн Элчин сайд нарын ажлыг дүгнэхэд ч, Гадаад яамны ажлыг дүгнэхэд ч их ойлгомжтой болох болов уу гэсэн бодолтой байна. Тэгэхээр дараа дараа тайлангаа оруулж ирэхдээ яг тийм задгай дүгнэлтүүд хийгээд нэлээн тийм ээ ангилаад аль нь юунаас болов гэдэгтэйгээ оруулж ирвэл хэрэгтэй шүү. Энэ дээр бас онцгой анхаарал тавьж ажиллаарай.

Г.Занданшатар: Баярлалаа. Сайн байна. 2 минутад багтаасан. Ням-Осорын Учрал гишүүн бас 2 минутад багтаана.

Н.Учрал: Элчин сайдад нэр дэвшигч нарыг бүгдийг нь дэмжиж байгаа. Мэдээж Элчин сайдууд тус орныхоо эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, стратегийн түншлэлийг бэхжүүлэх, хувийн хэвшил, компани ААН-үүдийг холбох нь чухал хэдий ч энэ БНСУ-д суух Элчин сайд их онцлогтой юм. Солонгост амьдарч байгаа 50 гаруй Монголчуудынхаа эрх ашгийг хамгаалж, тэднийхээ дуу хоолой болж, жаргал зовлонгийнх нь ард хатуу зогсож чаддаг, хүний төлөө сэтгэлтэй хүн томилогдох ёстой. Тэр ч утгаараа бас би Энхбат нэр дэвшигчийг өнгөрсөн хугацаанд олон бас тэнд амьдарч байгаа Монголчуудтайгаа хамтдаа бас мөр зэрэгцэн амьдарч, ажиллаж, тэднийхээ бас жаргал зовлонг мэддэг ийм хүн

томилогдож байгаа би сэтгэл дүүрэн байгаа юм. Тэр дипломат харилцааг өргөжүүлэхээс илүү чухал зүйл тэнд амьдарч байгаа Монголчуудынхаа эрх ашгийг хамгаалах шүү. Үнэхээр өвдөж зовсон, эрүүл мэндийн шалтгаантай олон Монголчууд элчин сайд нь хүрч ирээд Солонгос соёлоор нь, Солонгос хандлагаар нь, Солонгос хэлээр нь тухайн өвчтөнийхөө төлөө эмнэлгийнх нь удирдлагуудтай уулзаад зогсоход бол олон Монголчууд чин сэтгэлээсээ баярладаг. Тийм ч учраас энэ 50 гаруй Монголчууд Монголын олон айл өрхийн амьдралыг ар нуруун дээрээ авч явж байгаа. Тэднийгээ ялгахгүй чин сэтгэлээсээ харилцаж чадах ийм бас нэр дэвшигч томилогдож байгаа. Тийм ч учраас дипломат албаны туршилага гэхээсээ илүүтэйгээр яг тэдний жаргал зовлонг мэддэг хүн энэ Солонгост томилогдоно гэдэг бол энэ Солонгост байгаа олон Монголчуудад их тус дөхөм болно.

Тэгээд Энхбат нэр дэвшигчид амжилт хүсье. Тэгээд дуу хоолой нь болж, эрх ашгийг нь хамгаалж, ялгахгүй сайхан харилцаж, ажиллаарай л гэж хүсье.

Г.Занданшатар: Үг хэллээ. Гонгорын Дамдинням гишүүн. 2 минут.

Г.Дамдинням: Монгол Улсын Засгийн газраас шийдээд ороод ирж байгаа хүмүүсээс асуух юу байх вэ. Би Канад улстай их ойрхон ажилладаг. Суралцаж төгссөн. Канадын бизнесменүүд хөрөнгө оруулалтыг дэмжиж бас энэ улсын сурах ёстой туршилагуудыг Монгол Улсад нэвтрүүлэх ёстой гэж хатуу итгэж явдаг. Тэгээд Канад улсад томилогдож байгаа Сарантогос нэр дэвшигчид хэдэн зүйлийг захимаар байна.

1 дүгээрт, манай улсад байгаа хамгийн том гаднын хөрөнгө оруулагч бол Канад улс. 1 тэрбум долларын хөрөнгө оруулалтыг бодитойгоор

оруулаад Оюутолгой төсөл дээр ажиллаж байгаа ийм улс. Уул уурхайн дэлхийн тэргүүлэх улсуудын нэг. Энэ улсаас бид нар энэ бизнесийн хамтын ажиллагааг хамгийн их хийх ёстой шүү. Дипломат харилцаанаасаа гадна. Тэгэхээр энэ уул уурхайтай холбоотой олон арга хэмжээнүүд болдог, зохион байгуулалт хийгддэг. Энд Элчин сайдын яамнаас бас яг дипломат харилцаа гэхээсээ гадна энэ бизнесийн харилцааг хөгжүүлэх чиглэлд Монголд байгаа уул уурхайн компаниуд хэрхэн гарах вэ гэдэг асуултыг байнга асууж байдаг юм. Түүн дээр нь сургалт, зөвлөгөөн зохион байгуулах, холбох энэ ажлыг бас их сайн хийгээрэй л гэж хүсье. Тэгээд яг 2 орныхоо хамтын ажиллагаанд хувь нэмрээ оруулж ажиллана гэдэгт итгэлтэй байна. Тэгээд амжилт хүсье.

Г.Занданшатар: Энхтайваны Бат-Амгалан гишүүн 2 минут. Дараа нь санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд.

Э.Бат-Амгалан: Элчин сайдаар томилогдохоор орж ирж байгаа нэр дэвшигч нартаа баяр хүргэе. Ер нь яах вэ, зүгээр орчин үеийн дипломат харилцаанд нэг 2 чиглэл бариад байна уу л гэсэн ийм хандлагаар харж байгаа.

Нэг нь бол карьерын дипломатчид, нөгөөх нь тухайн улс орны аливаа нэг салбараар мэргэжисэн ийм дипломатчдыг томилдог ийм жишиг байгаа. Тэгэхээр ер нь сүүлийн үед энэ Гадаад харилцааны яам, Засгийн газраас оруулж ирж байгаа энэ томилгоонууд ер нь яг энэ 2 чиглэлийг бариад явж байгаа юм. Энэ дээр их сайшаалтай хандах хэрэгтэй. Ер нь Гадаад харилцааны яамдаа бас баяр хүргэх нь зүйтэй гэж ингэж бодож байгаа.

Ер нь яах вэ, зүгээр энэ улс төрөөс тэтгэвэрт гарсан нөхдийгөө Элчин сайдаар явуулчихдаг ийм үе нэгэнт өнгөрчээ. Энэ мэргэжлийн хүмүүс орж ирж байгаа нь сайшаалтай санагдаж

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

байна. Ялангуяа тэр Байнгын хороон дээр яригдсан зарим нь төрийн байгууллагад ажиллаагүй энээ тэрээ гэсэн бас нэг шүүмжлэлүүд гарч байна лээ. Би зүгээр тухайн улс орондоо, тухайн улс орныхоо хэл, ёс, заншил, нийгэм, эдийн засгийн салбарт нь маш сайн ажиллачихсан ийм хүмүүс орж ирж байгаа нь сайн байна. Жишээ нь энэ Японд томилогдож байгаа Баярсайхан Элчин сайдын хувьд үнэхээрийн Япондоо сургуулийг нь төгсчихсөн, хэл, ёс заншилыг маш сайн япон хүнээс дутахааргүй ингээд эзэмшичихсэн байгаа. Мөн Монгол Улсын хөгжлийн бодлого энэ 2050 алсын харааг бас одоо, зорилго зорилтыг, хөтөлбөрийг бас бичилцсэн ийм хүн байгаа.

Тэгээд ер нь Элчин сайд нартаа амжилт хүсье. Хамгийн гол нь тэнд очоод түрүүний Даваасүрэн гишүүний хэлж байсан иргэдтэй, ААН-үүд, тэр хөрөнгө оруулалтын чиглэлийг л маш сайн татаж ажиллах нь зүйтэй гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа. Амжилт ... /минут дуусав/

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ер нь 2 минутад багтааж асуулт асууж, үг хэлж болох жишигийг Нямаагийн Энхболд нарын гишүүд бас үзүүллээ. Үүнээс хойш 2 минутаар явж байя.

Санал хураалт явуулна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар Элчин сайд нарыг эгүүлэн татах асуудлаар нууц санал хураана.

1. Монгол Улсаас Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Отгоны Дамбийнямыг,

2. Монгол Улсаас БНКУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шагдарын Батцэцэгийг,

3. Монгол Улсаас Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дамбадаржаагийн Батжаргалыг,

4. Монгол Улсаас БНСУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Эрдэнэцогтын Сарантогосыг,

5-д, Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболдыг эгүүлэн татах саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

Ойлголоо, 12 хүн татгалзсаны нэг нь Нямаагийн Энхболд гишүүн байсан бөгөөд энэ кноп нь ажиллаагүй учраас протоколд тэмдэглэж үзье. Санал хураалт боллоо.

Санал хураалт дэмжигдсэн учраас Элчин сайд нарыг эгүүлэн татах тогтоол батлагдсанд тооцлоо.

Одоо Байнгын хорооны саналаар Монгол Улсаас БНКУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сэсээрийн Золжаргалыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураана. Санал хураалт.

Ховд аймгаас 2 элчин сайд төрж байгаа түүхэн өдрүүд тохиож байгаа явдалд баяр хүргэе.

35 гишүүн дэмжиж, 77.8 хувийн саналаар Сэсээрийн Золжаргалыг томилох санал дэмжигдлээ.

2. Монгол Улсаас Япон улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Баярсайханыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураана. Санал хураалт.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

33 гишүүн дэмжиж, 71.7 хувийн саналаар Монгол Улсаас Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Банзрагчийн Баярсайханыг томилох тухай саналыг дэмжлээ.

3. Монгол Улсаас БНСУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Батнямын Энхбатыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя.

28 гишүүн дэмжиж, 60.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсаас Канад улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Эрдэнэцогтын Сарантогосыг томилох тухай саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор нууц санал хураалт явуулъя.

37 гишүүн дэмжиж, 80.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Чуулганы нэгдсэн хуралдаан дээр явагдсан санал хураалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлнэ.

Нэр дэвшигч Элчин сайд, Гадаад харилцааны яамныханд баярлалаа.

18.01 цаг

Дараагийн асуудалд орно. Гишүүд байж байгаарай.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Дэлгэрсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол

Улсын Засгийн газраас 2023 оны 01 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 04 сарын 27-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон зарчмын зөрөөтэй саналын томъёололтой холбогдуулан гишүүдээс асуулт асууж, санал гараагүй болно.

Хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед хуулийн төслүүдийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан 2 санал хураалт явуулсан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжсэн болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж, тусган төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулга болон зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх гэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Дэлгэрсайхан гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Пүрэвжавын Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Эрхэм-Ундрах.

Эрхэм-Ундрах Дорнод, Сүхбаатараар сайн явсан уу, тийм ээ, зурагтаар гараад л байна лээ.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрөөтэй 2 санал байгаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй 2 саналыг санал хураалт явуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 46¹.1 дэх хэсгийн “Шаардлагатай” гэсний өмнө “Засгийн газар” гэж нэмэх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

58.7 хувийн саналаар санал дэмжлээ.

2.Төслийн 6 дугаар зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг,” гэснийг “3 дугаар зүйлийг,” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

18.06 цаг

Дараагийн асуудалд оръё, сууж байгаарай.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа танилцуулна. Индэрт урьж байна.

Ш.Адьшаа: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 сарын 18-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 04 сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хууль зүйн байнгын хороо 2023 оны 05 сарын 02-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д заасныг баримтлан “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан 2023 оны 05 сарын 03-ны өдөр хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хороонд хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Асуулт хаачихсан шүү дээ. Раднаасэд гишүүн заавал асуух юм уу. Заавал асуух шаардлага байгаа юм уу.

Санал хураалт явуулахгүй бол 6 цаг өнгөрч байна.

Сайлаа бэлдэхээр саваа бэлд гэж үгтэй шүү. Санал хураалтад бэлтгэе. Санал хураалтыг. Жавхлан сайд суу, санал хураалт.

“Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлуулах Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Пүрэвдорж гишүүн суудалдаа суучих.

Б.Пүрэвдорж: Би дэмжихгүй байна.

Г.Занданшатар: Үгүй ээ, дэмжихгүй байлаа ч гэсэн суудалдаа суучих, дэмжихгүй байлаа ч гэсэн суудалдаа суучих. Та хүний суудал дээр Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдалд халдаж байна даа. Хүний суудлыг эзэгнээд кнопыг нь дараад ингээд удаа дараа зөрчил гаргавал. Ингээд суудалдаа сууж байгаад сайхан саналаа өгчих хэрэгтэй шүү дээ.

Санал хураалт. 51.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороо шилжүүлж байна.

Баярлалаа, ажлын хэсэгт. Сайнзориг оо, чи ер нь сайн залуу шүү, сайн мэргэжилтэн шүү, чи.

18.11 цаг

Ингээд дараагийн асуудал орё.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир гишүүн танилцуулна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 12 дугаар сарын 30, 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 04 дүгээр сарын 25, 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслүүдтэй холбогдуулан Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг дахин хэлэлцэх шаардлагатай гэсэн горимын санал гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд буцаасан.

Төсвийн байнгын хороо 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулж, өмнөх хуралдаанаар хэлэлцсэн зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг дэмжин, нэмж боловсруулсан зарчмын зөрөөтэй саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэх горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Үүнд:

1.Эм, эмнэлгийн хэрэгсэл, чанар ба үнийн хосолмол үнэлгээ хийх шалгуурыг хуулийн төсөлд шинээр нэмж, чанар ба үнийн хосолмолд хамаарах оноог тендер шалгаруулалтын баримт бичигт тендер зарлахаас өмнө тусгах,

2.Хүн амын эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой олон улсын чанарын шаардлага хангасан эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгч олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах зохицуулалтыг өөрчлөн найруулах,

3.Төрийн аудитын тухай хуульд заасан аудитад шинжээч сонгон оролцуулахтай холбогдох, худалдах, худалдан авах ажиллагааг энэ хуулийн үйлчлэх хүрээнд хамааруулахгүй байх зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгах,

4.Шүүх шинжилгээний хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай уялдуулан шүүх шинжилгээний байгууллагын нарийн мэргэжлийн шинжилгээнд шаардлагатай урвалж бодис нийлүүлэх боломжтой этгээдийн тоо хязгаарлагдмал бол шууд гэрээ байгуулна гэсэн саналууд гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг хуулийн төсөлд тусгасан төрийн өмчийн музей болон галерейн сан хөмрөгийг баяжуулах зорилгоор түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг нэг өмчлөгчөөс буюу нэг эх үүсвэрээс худалдан авах аргад орон нутгийг хамруулах нь зүйтэй гэсэн зарчмын зөрөөтэй санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт зарчмын зөрөөтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийн явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Болдын Жавхлан Сангийн сайд, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Ганболдын Гийхнаран, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Цэдэнбалын Батзул, Барилга, хот байгуулалтын яамны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн Бодлого зохицуулалтын газрын дарга Доржсаламын Гантулга, Монгол Улсын ерөнхий аудиторын орлогчийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч Цэвэгсүрэнгийн Наранчимэг, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал тэргүүлэх аудитор Буянтогтохын Бундхорол.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Балжиннямын Баярсайхан гишүүнээр тасаллаа. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьшаа: Засгийн газраас өргөн барьсан энэ хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Энэ төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах энэ үйл явцыг шинэ шатад гаргах бас шинэлэг зүйл орсон гэж ойлгож байгаа. Гэхдээ энд бас нэг зарим зүйлийг тодруулах шаардлагатай байна. Өнөөдөр төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдаж авах энэ үйл явц өнөөдөр нийгэмд хамгийн их хардалт, хамгийн их хууль зөрчсөн, төсвийн хөрөнгийг тендер нэрээр авдаг, түүнчлэн энэ захиалагч болон гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагатай холбоотой асуудал энд бас нэлээн маргаан дагуулдаг асуудал байгаа. Ялангуяа өнөөдөр энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдаж авах энэ үйл ажиллагааны хүрээнд бүр ийм мэргэжлийн ийм аливаа асуудлыг самууруулдаг, бууруулдаг ийм том бүлэглэл бий болсон байгаа шүү дээ. 20 сая төгрөгийн маргааны дэнчин тавиад тэгээд л тэнд олон компаниуд маргалдаад, цаашлаад энэ тендер шалгаруулалт гацаадаг, улмаар шүүхэд ханддаг. Тэгээд үүний үр дүнд яадаг вэ, улсын төсвийн хөрөнгөөр хийх бараа үйлчилгээний үйл ажиллагаа саатдаг. Тэгээд шүүх энэ дээр нөгөө л хамгийн буруу арга барилаараа үүнийг одоо шийддэг. Тэгээд л энэ асуудал үр дүнд хүрдэггүй. Эцэст нь ямар байдалд хүрдэг вэ гэхээр төсвийн хөрөнгө оруулалтаар явах тэр ажил гацдаг. Энэ тогтолцоо

дээр ямар шинэлэг зүйлийг энд оруулж ирсэн бэ гэж нэг асуултад хариулт авъя.

Түүнчлэн энэ маргаан тэмцээн хийгээд ялагдал хүлээгээд түүнийгээ цаашидаа тахимаа өгөхгүйгээр олон шат дамжлага үр дүнд энэ үйл ажиллагааг зогсоодог энэ системийг задлахын тулд тэр 20 саяын дэнчинг бүр өргөн хэмжээгээр 200 сая ч гэдэг юм уу. Түүнчлэн энэ үүрэг хариуцлагыг чангатгах талаар ямар зохицуулалтыг энд тусгасан бэ? Энэ талаар бас нэг иргэд, олон нийт, энэ бизнес эрхлэгчид энд нэг энэ хуулийн төслийг санаачлагч болон энэ хүмүүст нэг хариулт өгмөөр байна.

Түүнчлэн өнөөдөр чанаргүй барилга объект барьдаг, түүний чанаргүйг мэдсээр байж хүлээж авдаг төрийн албан хаагчдын хариуцлага, хууль зөрчсөн үйлдэлд хүлээлгэх арга хэмжээний талаар энэ хуульд ямар зохицуулалт тусгасан бэ? Үүнийг цаашид хэрэгжүүлэх талаар нэн ялангуяа энэ Сангийн яам, энэ Худалдан авах ажиллагааны газар энд ямар дүгнэлт хийж, зарчмын ямар шийдэл гаргах, бодлогыг баримталж байгаа талаар нэг хариулт авъя.

Г.Занданшатар: 82 Батзул хариулъя.

Адъяаа гишүүний асуултад хариулъя. Төрийн худалдаа үйлчилгээний газар Батзул. 1 дүгээрт нь, ил тод байдлын хүрээнд одоо хуульд тендер шалгаруулалт зохион байгуулаад үнэлгээний хорооны дүгнэлтийг нь захиалагч тухайн тендерт оролцсон ААН-үүдэд нь үзүүлэх ёстой болж байгаа. 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр тендер шалгаруулалтад оролцоод ялагдсан ААН-үүд бол ялсан компанийн материалтай танилцах эрхтэй болсон. Үүний үр дүнд ер нь нийт тендер шалгаруулалтын 20 орчим хувьд нь гомдол гардаг байсан нь бол 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт улсын

хэмжээнд зохион байгуулагдаж тендер шалгаруулалтын 3 хувьд нь гомдол гардаг байдлаар буурсан байгаа. Үүнийг бид нар юу гэж дүгнэж байгаа вэ гэхээр ил тод байдлыг нэмэгдүүлэх нь нөгөө хардлагыг бууруулж байгаа юм байна.

Нөгөө талдаа үндэслэлгүйгээр гомдол гаргаж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд нь бас сөрөг үр дагавар үүсгэдэг ААН-үүдэд нь 20 сая төгрөгийг хүртэл нөгөө тендерийн баталгааг нь улсын орлого болгодог хуулийн зохицуулалт 2019 оноос хойш хэрэгжээд эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор бас шинэчилсэн найруулгад 100 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулчихвал 60 сая, 100 хүртэл 20-100 тэрбумын төсөвт өртөгтэй бол 40 сая, тэгээд 20 тэрбумаас доош 20 хүртэлх саяын тендерийн баталгааг нь улсын орлого болгохоор хуулийн төсөлд тусгасан байгаа.

Энэ шүүхэд хянан шийдвэрлэх асуудал дээр бас бид нар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмын тухай хууль дагах хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. Энэ хүрээндээ Захиргааны хэргийн шүүх дээр материал цуглуулах асуудлаар нэлээдгүй хугацаа алддаг. Үүнийг нь хурдасгах үүднээс зөвхөн тендер шалгаруулалт буюу цахим тендерт ирүүлсэн материал дээр нь үндэслээд шүүх хянахаар ийм зохицуулалт оруулсан байгаа.

Нөгөө талдаа тэр хариуцлагагүй ААН-үүдэд нь бас нэлээдгүй өндөр санкцууд оруулж ирж байгаа. Одоо бол хуулийн этгээдийн зөвхөн тухайн хуулийн этгээд нь хариуцлага тооцоод 3 хүртэл жилийн хугацаагаар 3 жилийн хугацаагаар тендерт оролцох эрхийг нь хязгаарлаж байгаа. Одоо бол үүсгэн байгуулагч болон хувьцаа эзэмшигчдийн хамт бас эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд 3 жилийн хугацаатай бүртгэхээр болсон байгаа. Нөгөө талдаа бид энэ тендер шалгаруулалтад оролцсон

ААН-үүд нь ил тод байдлыг нь хангах үүднээс тухайн тендертэй холбоотой бүх процесс, үнэлгээний хорооны дүгнэлт, захиалагчийн шийдвэртэй нь тодорхой хугацааны хүрээнд танилцах боломжийг нь хуулиар нээж өгч байгаа. Тэгэхээр цаашидаа тендерт оролцсон ААН бол тендертэй холбоотой бүх мэдээлэлтэй танилцах эрхтэй болно. Хариулж дууслаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ш.Адьяа: Энэ тендерт шалгарчхаад тухайн жилийн төсөвт өртгийнхөө ажлыг хийхгүй байгаа олон ААН-үүд байдаг. 10 гаруй жилийн түүхтэй ч ААН-үүд байна. 1, 2 жилийн түүхтэй ч ААН-үүд байна. Энэ ААН-үүдийг цаашид ийм эрсдэл гаргахгүйн үүднээс ямар хариуцлага тооцох вэ. Ингээд төсөвт өртөгтөө багтаахгүй байдаг юм уу. Мөн түүнчлэн энэ зураг төсвийн байгууллага гэж нэг хачин байгууллага байгаа шүү дээ. Нуух юм байхгүй, зураг төсвийн байгууллага гэдэг тийм шантаажны байгууллага байгаа. Аливаа юмыг шантаажилдаг, захиалагчтай хуйвалддаг, түүнчлэн гүйцэтгэгчтэй хуйвалддаг. Энэ үйл ажиллагааг цаашид гаргахгүйн тулд ямар зохицуулалтыг үүгээр хийх вэ гэдэг ийм нэг асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: Батзул гишүүн хариулъя.

Ц.Батзул: Адьяа гишүүний гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөл дээр орж ирж байгаа нэг онцлог заалт бол энэ ААН-үүдийн одоо гүйцэтгэж байгаа ажил болон санхүүгийн нөөц бололцоо, чадавх, туршилагын асуудал дээр нь яг цаг тухайд нь ямар ажил эрхэлж байгаа асуудлаар нь бүртгэл хөтлөөд, тэр ажил нь хэдэн хувьтай явж байгаа юм, хэн хэн гүйцэт ажиллаж байгаа юм, ямар тоног төхөөрөмж ашиглаж байгаа гэдгийг нь

бодит цагийн горимоор ингээд бусад мэдээллийн системтэй холбоод тэр систем дээрээ үндэслээд дараагийн шийдвэр гаргах юм. Тэгэхээр тухайн тендерт оролцогчийн одоо гүйцэтгэж байгаа ажил нь нөөц бололцооноос нь давсан байх юм бол дараагийн тендерт нь шалгаруулахгүй байх ийм зохицуулалт оруулж байгаа.

Тэгээд үндсэндээ одоо гүйцэтгэж байгаа нөөц бололцоо нь хангалттай эсэх дээр нь үндэслээд үнэлгээний хорооны шийдвэр гардаг болно гэж байгаа. Үүнийгээ цахим системийн бүртгэл болон энэ холбогдох хууль тогтоомждоо тодорхой заагаад өгчихсөн байгаа. Хариулж дууслаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би 2 зүйлийг тодруулчихъя. Ажлын хэсгээс.

1 дүгээрт, нь энэ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөрөө бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль дээр хамгийн их гардаг юм бол энэ хар жагсаалттай холбоотой асуудал байгаа юм. Үүнийг бид нар энэ хариуцлагын тогтолцоог сайжруулж өгөхгүй бол болохгүй байгаа юм. Тэгэхгүй бол зарим компаниуд ингээд ажлаа авдаг, үнэ нь ойр ойрхон нэмэгддэг, тэгээд хугацаандаа ажлаа хийдэггүй, хийсэн ч чанарын шаардлага хангадаггүй эд нар гээд байх олон тодотголууд гардаг. Үүнтэй холбоотой хамгийн чухал юм бол компаниудын хар жагсаалтын асуудал байгаа юм. Тэгээд энэ хууль дээр нь компанийн хар жагсаалтын асуудал, хариуцлагын асуудлыг яаж авч үзэв. Орж ирсэн төслөөс хэрхэн сайжруулав гэдгийг би 1 дүгээрт нь, асуух гээд байгаа юм.

2 дугаарт, энэ Засгийн газраас нэг ийм санал ирээд байгаа юм. Энэ томоохон төслүүд дээр Засгийн газраас хэрэгжүүлэх улс орны хэмжээний томоохон төслүүд дээр харьцуулалтын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

аргаар тендерийн асуудлыг шийдмээр байна. Ингэхгүй бол нөгөө том тендер учраас шүүхээр явдаг, тэгээд энэ маргаан нь 2, 3 жил үргэлжилдэг ийм асуудал байна гээд байгаа юм. Тэгэхээр энэ зарчмын зөрөөтэй саналууд дээр энэ дараагийн хэлэлцүүлэг дээр харьцуулалтын аргыг авч үзэх, харьцуулалтын аргыг оруулах тийм боломж байна уу? Хууль, эрх зүйн хүрээндээ гэдэг ийм 2 зүйлийг тодруулъя.

Г.Занданшатар: 82, ажлын хэсэг.

Ц.Батзул: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн энэ хууль хэрэгжээд 23 жил болж байгаа. 2005 оноос хойш 18 жилийн хугацаанд хар жагсаалт болон энэ чанар, чанаргүй барилга, гэрээний гүйцэтгэл хангалтгүй асуудлаар бас судалгаа хийж үзсэн байгаа. Тэгээд энэ дээр бид нар дүгнэлт хийгээд ер нь энэ тендерт оролцогч ААН-үүдийн хэрэгжүүлж байгаа ажил өмнө нь хэрэгжүүлсэн ажил дээр нь бүртгэл хөтлөөд, энэ бүртгэл дээрээ үндэслээд дараагийн шийдвэрээ гаргадаг болох нь хамгийн зөв юм байна. Энэ хүрээндээ энэ худалдан авах ажиллагааны цахим системийг бусад төрд байгаа мэдээллийн системтэй холбож, мэдээлэл солилцох боломжоор нь хангаад, тэгээд тухайн тендерт оролцсон ААН нь өмнө нь гүйцэтгэсэн ажил нь чанаргүй, тэгээд хугацаандаа гүйцэтгээгүй байх юм бол тендерээс нь татгалзана. Энэ нь хуульд заасан журмын дагуу хар жагсаалтад орохоор байх юм бол үүсгэн байгуулагч болон хувьцаа эзэмшигчдийнх нь мэдээлэлтэй нь хамт 3 хүртэл жилийн хугацаагаар хар жагсаалтад оруулна.

Тэгэхээр цаашидаа нөгөө захиалагч болгон дээр өөрт нь шаардсан материалынхаа хүрээнд нь тендер бэлтгээд ордог байсныг нь таслан зогсоогоод, яг бодит мэдээлэл дээр үндэслээд тендерийн үнэлгээг хийх боломжийг нь олгож байгаа юм. Тэгэхээр нийслэлд нэг тендерт орохдоо би энэ ажлаа хийчихсэн гэж мэдэгдээд

нөгөө газар очихоороо үүнийгээ хийж байгаа гэж зөрөөтэй мэдээлдэг асуудал нэг мөр цэгцлэгдэнэ. Тэгэхээр цаашид ингэж нөөц бололцооноосоо давсан гэрээ хэрэгжүүлэх эрх авахгүй гэсэн байдлаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

Мөн цахим системийг энэ хэмжээнд холболтыг нь хийнэ гэсэн байдлаар хуулийн төсөлд тусгасан байгаа.

Томоохон төслүүдтэй холбоотойгоор Сангийн яамнаас өнгөрсөн онд хуулийн төсөл боловсруулж Засгийн газраас өргөн барьсан. Тэгээд Их Хурал дээр орж ирээд энэ том төслүүдийн энэ сонгон шалгаруулалтыг нь нээлттэй тендер шалгаруулалтын журмаар явуулах нь зөв юм гээд. Тэгээд шийдэгдсэн учраас дахиж энэ асуудал хуулийн төсөлд тусаагүй. Тэгээд харьцуулалтын аргын тендер шалгаруулалт нь Засгийн газраас тогтоож байгаа босго үнэд буюу бага хэмжээний худалдан авах ажиллагаа нь мөрдөгдөхөөр хуулийн төсөлд тусгасан байгаа. Хариулж дууслаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

Б.Баярсайхан: Баярлалаа. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг зарчмын хувьд дэмжиж байгаа. 3 асуулт байна.

1 дүгээрт, энэ эмийн чанарын асуудал, эмийн тендерийн асуудал яаж явагдах талаар энэ хуульд яг яаж тусаж байгаа вэ? Яагаад өнөөдөр Монголчуудын ууж хэрэглэж байгаа эм тариа чанаргүй, яг адилхан нэртэй мөртөө гадаад улсад байгаа адилхан эм тариа чанарын хувьд ингээд зүйрлэшгүй ийм сайн байдаг юм бэ? Тэгээд өнөөдөр Монголын эмийн тендерт хэчнээн компаниуд ордог юм? Антект байгаа, эмнэлгээр зарж байгаа энэ ялангуяа юун

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

дээр их илэрдэг вэ гэхээр эрхтэн шилжүүлсэн хүмүүсийн дараах тэр эмчилгээ дээр Монголд байгаа эмийн чанарын асуудал, сая бас нэлээн шуугиан болж байсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд уналт таталтын эсрэг эмийн чанарын асуудал, наад захын хүүхдүүд ханиад хүрэхэд ч гэсэн Монголд худалдаалагдаж байгаа эмийн чанарын асуудал үнэхээр шаардлага хангахгүй байгаа гэдгийг би мэдэж байгаа. Тэгэхээр энэ хуульд энэ эмийн чанарын асуудал, эмийн тендерийн асуудал яаж дуусаж байгаа юм.

2 дугаарт, энэ барилгын тендерийн асуудал гэж нэг ийм дампуурчихсан ажил байна. Хамгийн бага үнээр тендерт ялчихаад, яг ажлаа гүйцэтгэж байгаад яадаг вэ гэхээр ажлаа зогсоочихдог, нэмэлт санхүүжилт хэрэгтэй гээд. Ингээд нэмэлт санхүүжилт шаардаад л ингээд л нөгөө барилгаа царцаагаад л нөгөө барьсан хэсгээ чанаргүй болгоод л ингээд суугаад байна. Ингэж байгаад Барилга, хот байгуулалтын яамны харьяа энэ Барилгын хөгжлийн төвийн тэр магадлан гэдэг юмаар ороод ингээд л төсөвт маш их хүндрэл учруулсан, орон нутагт маш их чирэгдэл болсон, чанаргүй барилгууд ингээд боссон ийм түүхтэй байна. Энэ хуульд энэ асуудал яаж тусаж байгаа юм. Энэ хууль батлагдсанаараа энэ асуудал цэгцрэх юм уу гэдэг асуудал байна.

3 дугаарт, энэ өнөөдрийн төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр энэ бараа, ажил үйлчилгээ чанаргүй хийгдчихсэн ажлуудыг яах юм. Би сонгогдсон цагаасаа Завхан аймагт энэ чанаргүй барилга бол үнэхээр сум болгонд байгаа гэдгийг хэлж байгаа, энэ би хэлж байгаа шүү. Энэ асуудал орон нутагтаа ингээд мананжаад юм уу бие биеийгээ ингээд хаацайлаад, Сангийн яам, Аудитын газар, Авлигатай тэмцэх газар нь мэдэж байгаа ч гэсэн энэ асуудал шийдэгдэхгүй байгаа.

Завхан аймагт ямар асуудал гарч байсан гэхээр хувиараа, хүслээрээ эхлээд баахан цэцэрлэг барьчихаад, улсын хөрөнгөөр тэр цэцэрлэгээ буцаагаад худалдуулаад ингээд авчихдаг ийм асуудал гарсан. Тэгэхээр энэ хэлэлцэгдэх гэж байгаа энэ хууль дээр энэ асуудал яаж тусгах юм. Ийм асуудал дахин цаашаа гарахгүй гэх баталгаа байна уу? Эдгээр асуултуудад хариулт авъя.

Г.Занданшатар: Асуултад 82, Батзул хариулъя.

Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Төрийн худалдан авах үйлчилгээний газар Батзул. Эмийн чанарын асуудлаар бас өнгөрсөн 4 дэх өдрийн чуулганаар олон гишүүн асууж ярьсан. Тэгээд энэ эмийн чанар бас үнэхээр манай Монголд асуудал болсон уу гэвэл болсон. Тэгээд тендер шалгаруулалт дээр орж ирж байгаа эмийн чанарын асуудал дээр бид нар бас Эрүүл мэндийн яамтай тусгайлан Их Хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу ажлын хэсэг бас ажиллаад, хуулийн төсөлд хэд хэдэн заалтыг оруулсан. Цаашидаа эмийн тендер шалгаруулалтыг үнэлгээг нь чанар болон үнэлгээний хосолмолоор, тэгээд чанарыг нь голчлох байдлаар тендерийн үнэлгээ буюу санал болгож байгаа эмүүдийг чанараар нь эрэмбэлэх ийм зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан.

Нөгөө талаас энэ эмийн чанарыг сайжруулах хүрээнд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олон улсын чанарын шаардлага хангасан гадаадын үйлдвэрлэгчээс эмийг нэгдсэн журмаар худалдан авах энэ зохицуулалтыг нь оруулж өгсөн байгаа. Хуулийн төслийн 36.1.2-т энэ зохицуулалтыг нь тусгайлан заасан.

Мөн нэмэлтээр анхны хэлэлцүүлэгт буцаасантай холбогдуулаад 36.4 дэх хэсэгт энэ эмийн худалдан авах ажиллагааг хэрхэн зохион байгуулах

журмыг нь тусгайлан Засгийн газар батлахаар заасан байгаа.

Тэгээд үүнээс гадна тэр барилгын чанартай холбоотой асуудлаар ажлын хэсэг Барилгын яаман дээр бас уулзсан. Барилга, хот байгуулалтын сайд болон Барилгын яамны холбогдох албан тушаалтнууд Барилгын хуульд бас нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажлын хэсэг гаргасан. Энэ чанартай холбоотой барилгад тавигдах стандартыг нэмэгдүүлэх асуудлаар хуулийн төсөл боловсруулаад явж байгаа. Тэгээд энэ дээрээ бид нар явцын хяналт болон гэрээний хэрэгжилтийг нь хуулийн төсөлд ил тод мэдээлэх, тэгээд энэ чанарын шаардлага хангаагүй барилга, барилгын ажил гүйцэтгэсэн ААН-ийг нь дахиж тендерт шалгаруулахгүй байх, тэгээд энэ гүйцэтгэлийнх нь чанар болон гүйцэтгэлийн явцыг нь дараагийн тендерийн үнэлгээнд нь харгалзаж үздэг байхаар хуулийн төсөлд тусгасан. Тэгэхээр өмнөх ажлуудаа ингээд чанаргүй хийгээд л яваад байдаг тэгээд тэрийг нь хүлээж аваад байдаг асуудал нь болохоор тодорхой хэмжээнд шийдэгдэнэ гэж үзэж байг.

Нөгөө талдаа энэ чанаргүй барилга хүлээж авч байгаа асуудал нь болохоор яг тендерийн хуулийн харилцаанаас гарчхаад байгаа юм. Барилгын хуулиараа явцын хяналтыг үздэг. Тэгээд тэр хүрээндээ болохоор тодорхой норм, журам, дүрмүүд нь бүгдээрээ Монгол Улсад байгаа, түүнийгээ баримтлах ёстой юм байна гэдэг дээр ажлын хэсэг уулзаад, нэгдсэн байр сууринд хүрсэн байгаа.

Цаашидаа энэ барилгын ажил чанаргүй гүйцэтгэсэн ААН-үүд дээр нь нөгөө хар жагсаалтын асуудлаа ярина. Түрүүний миний хэлсэн нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн бол дахиж тендер өгдөггүй байх. Энэ асуудлыг нь хуулийн төсөлд нэг мөр тусгасан байгаа. Тэгээд нөгөө үнээ нэмэгдүүлдэг асуудлыг нь болохоор хуулийн төсөлд бас тодорхой зааж өгөөд

анхны гэрээний үнэд нь гүйцэтгэдэг байх, хэрвээ гүйцэтгэж чадахгүй бол хариуцлага тооцдог байх энэ зохицуулалтыг нь оруулж өгсөн байгаа.

Нөгөө талаас бас 2023 онд Их Хурлаас шийдвэр гаргаад шинэ төсөл арга хэмжээг 23 онд эхлүүлэхгүй байх, одоо эхлүүлсэн байгаа ажлаа бүрэн дуусгах хүрээнд шинэ төсөл арга хэмжээ эхлээгүй явж байгаа. Тэгэхээр энэ оноос эхлээд энэ дутуу гүйцэтгэдэг, барилгын үнээ нэмэгдүүлдэг асуудлууд цэгцрээд явна гэж үзэж байгаа. Хариулж дууслаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууя.

Б.Баярсайхан: Ингээд нэг сайхан хууль гаргаад яг хариуцлага ярих болохоор нэг нь барилгын хууль руу явчихдаг. Тендерийн хуульдаа багтаагүй гэдэг ийм зүйлийг бас яримааргүй байна. Тэгээд энэ хууль хэлэлцэж явах хугацаанд үүнийгээ сайжруулаад хариуцлагын тогтолцоог сайжруулмаар байна. Жишээлбэл, Монгол Улсад чанаргүй ийм юм оруулж ирж байгаа, энэ тендерийг гардан гүйцэтгэж байгаа, тендерийн хороонд ажиллаж байгаа төрийн албан хаагч нарт ямар хариуцлага тооцох юм бэ? Хувийнхантай ингээд хар жагсаалтад оруулаад байх юм байна.

Энэ чанаргүй барилга, чанаргүй барилга барьж байгааг нь мэдсээр байж удаа дараа нэг компаниудыг дэмжээд яваад байгаа, энэ өөрөөр хэлбэл энэ төрийн албан хаагчдад худалдан авах ажлыг зохион байгуулж байгаа төрийн албан хаагчдад та нар ямар хариуцлага хүлээлгэх юм бэ. Энэ нь энэ хуульдаа байгаа юм уу, хариуцлагын тогтолцоо хамгийн гол нь.

Г.Занданшатар: Тэмүүлэн гишүүн хариулах уу. Батзул.

Ц.Батзул: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Хариуцлагын

2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

асуудлаар бид хэд хэдэн зохицуулалтыг оруулсан. Хуулийн нөгөө хувийн хэвшилээс гадна төрийн албан хаагчдад бол хуулийн төслийн 61 дүгээр зүйл дээр хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой зохицуулалтыг нь оруулсан.

1 дүгээрт гэмт, хэргийн шинжгүй бол Төрийн албаны хуулиар мөн Хөдөлмөрийн хуулиар оруулж байгаа. Өмнөх хууль одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр Хөдөлмөрийн хууль ороогүй байсан учраас Хөдөлмөрийн хуулиар хариуцлага тооцох тогтолцоо байхгүй.

Нөгөө талдаа энэ хуулийн үйлчлэлийн хүрээнд төрийн болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээд нь захиалагчийн эрх үүргийг хэрэгжүүлээд бас хууль тогтоомжийн зөрчсөн үйлдэлд нь бас сахилгын болон Төрийн албаны хуулийн хариуцлага очихгүй байсныг нь эргээж хараад Хөдөлмөрийн хуулийн хариуцлагын заалтуудыг нь оруулж ирсэн.

Нөгөө талдаа энэ Авлигын тухай хууль болон ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал, хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй 39 санал байгаа.

Ингээд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооны гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.3.6 дахь заалтын “сурталчлах” гэснийг “сурталчлахтай холбоотойгоор гадаад улсаас бараа, үйлчилгээ авах” гэж

өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Жигжидийн Батжаргал, Жамбын Батсуурь, Цэрэнпилийн Даваасүрэн, Бөхчулууны Пүрэвдорж. Цаашид Ажлын хэсэг гэнэ. Санал хураалт.

53.8 хувийн саналаар.

Ажлын цаг дууссан байгаа учраас сунгаж хуралдах уу? Маргааш өглөө үргэлжлүүлэх үү? Өглөө болъё.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.ОЮУНГЭРЭЛ